

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-34
1. “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ, үргэлжлэл/	6-7
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	7-30
3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	30-31
4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/	31-34

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 23-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Заяабал,
Д.Пүрэвдаваа, Б.Түвшин;

Чөлөөтэй: Б.Мөнхсоёл, З.Мэндсайхан, Г.Тэмүүлэн.

Нэг. “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн зөвлөх Э.Нямбаяр, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Г.Өлзийсайхан, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Л.Төр-Од, мөн танхимын Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч Л.Батсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

“Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийн зөвшилцөх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Ц.Даваасүрэн: “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ж.Баясгалан, Д.Батлут нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 85.7 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, Б.Баярбаатар, Р.Батболд, Д.Батлут, П.Ганзориг, Д.Батбаяр, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 81.3 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 10
Бүгд: 16
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Илээр санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.” гэж заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16

56.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 25 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 ирж, ирц 52 хувьтай байна. Тийм учраас Төсвийн байнгын хорооны 4 сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Алтанхуяг гишүүн ирсэн байна. Батжаргал гишүүн ирсэн байна. Болормаа гишүүн ирсэн байна. Ганзориг гишүүн ирсэн байна. Чойжилсүрэн гишүүн ирсэн байна. Батбаяр гишүүн ирсэн байна. Батлут гишүүн ирсэн байна. Ж.Ганбаатар гишүүн ирсэн байна. Миний бие ирсэн байна. Батболд гишүүн ирсэн байна. Батцэцэг гишүүн ирсэн байна. Г.Ганбаатар гишүүн ирсэн байна. Мөнхтулга гишүүн ирсэн байна. Баясгалан одоо гишүүн бүртгүүлж байна. Ингээд 14 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Өнөөдрийн хуралдааны ирц хангалттай байна.

Байнгын хороогоор 4 асуудал хэлэлцүүлэхээр товлосон байгаа. Эхний асуудал санал хураалт нь үлдчихсэн, хойшлогдсон. “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийг батлах асуудал байгаа.

2-т Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

3-д Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”

4-д “Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 4 төсөл байна.

Энэ хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал.

“Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлье.

Өнөөдрийн энэ асуудалд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүд өмнө нь танилцуулсан хэвээрээ байгаа. Өмнөх хуралдаан дээр танилцуулсан хэвээрээ байгаа.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцээд, гишүүд ажлын хэсгээс асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.3-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Чойжилсүрэнгийн горимын саналаар хэлэлцүүлгийг түр хойшлуулсан. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлаар санал хураалтаар ингээд үргэлжлүүлээд явна. Ингээд санал хураалтад бэлдээрэй гишүүд ээ. “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зөвшилцсөн саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. Зөвшилцье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар дэмжигдсэн байна. Мөн протоколд Батбаяр гишүүн, Баясгалан гишүүн нар дэмжсэн. Батлут гишүүн бас дэмжсэнээр авлаа. Ингээд “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад байдлын байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

“Монгол Улс болон Евро Азийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэж дууслаа.

10.29 цаг

2 дахь асуудал.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Х.Цэрэнханд мөн яамны мэргэжилтэн юм байна.

Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулаад танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах гол нэрийн бүтээгдэхүүнээр хангаж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх,

нийлүүлэлтийг тасалдуулахгүй байж, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг эцэслэн баталсан билээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаан буудай гурил, улаан буудайн жагсаалтыг Засгийн газрын 180 дугаар тогтоолоор мөн баталсан.

Энэ хүрээнд улаан буудайн дээд болон 1 дүгээр зэргийн гурил, 9 нэр төрлийн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлсөн. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд гурилын импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирж байгаа гурилын хэмжээ эрс нэмэгдэж, жилийн эцсийн байдлаар 64,2 мянган тонн улаан буудайн гурил буюу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор 35,9 мянган тонн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14,1 мянган тонн, Увс аймгийн Боршоо боомтоор 10,3 мянган тонн, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт, Завхан аймгийн Арцсуурь боомтоор 3,9 мянган тонн улаан буудайн гурилыг ОХУ-аас тус тус импортолсон байна. Мөн 2025 он гарсаар эхний 4 сарын байдлаар нийт 17,1 мянган тонн улаан буудайн дээд болон 1 дүгээр гурил импортлоод байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулахад шаардлагатай мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 65,2 мянган тонн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 дахин их хэмжээний тэжээл импортолсон байна. Энэхүү нөхцөл байдал нь стратегийн хүнс болох улаан буудайн болон гурилын үйлдвэрлэл нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтворгүй болгож, тэдгээрт хийгдсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж үнэгүйдэх зэрэг эдийн засаг, нийгмийн олон сөрөг нөлөөг дагуулж болзошгүй байна.

Иймд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хууль нэгэнт зорилгодоо хүрсэн гэж үзэж буй учир Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Иймд хуулийн төслийг хэлэлцүүлж шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуух асуулттай гишүүн байна уу. Үг нь тусдаа. Батболд, Ганзориг гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхээр малын тэжээл, гурилын импортын гаалийн татвар тэглэсэн. Тухайн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ талаар бид нэлээн олон талаас нь судалгаа хийгээд, тийм шийдэлд хүрсэн. Гэхдээ энэ бол зүгээр нэг тийм дан гурил үйлдвэрлэл, үнийн асуудал биш байгаад байгаа юм. Бид хэд 60 хэдэн жил ноцолдсон газар тариалангийн салбартайгаа нягт уялдаатай, боловсруулах салбарынхаа үйлдвэрлэл хангамжийн асуудал дээр асуудал үүсгээд болж өгөхгүй байгаа юм.

Тийм учраас үүнийг бид их олон талаас нь зөв харах ёстой. 2020, 2021 оны үйл явц дэлхий нийтээр дахиад давтагдахгүй гэхийн баталгаа байхгүй. Тэр цаг үед бид өөрөө өөрсдийнхөө хүнсээрээ хангасан, сөрөн тэсвэрлэх чадвараа бий болгож чадсан л байх ёстой. Тэгэхээр энэ талаасаа асуудал юмандаа илүүтэй хандах болов уу гэж би ингэж ойлгоод байгаа. Тэгээд тодорхой 2, 3 зүйл байна.

Мэдээж энэ шийдвэр зорилгоо хангасан. Ойлгомжтой. 2024 оны 5 сард ер нь дотоодын 1 дүгээр гурилын борлуулалтын үнэ хэд байсан юм бэ. Өнөөдөр яг хэд байгаа юм бэ. Ямар өөрчлөлт үзүүлэв. Баруун бүс нутагт 1 дүгээр гурилын үнэ ямар байсан бэ. Өнөөдөр бас хэд болчихоод байгаа вэ. Ингэж нэлээн том анализ хийж, энэ дээрээ тулгуурлаж бас зөв бодлого зохицуулалтын арга хэмжээнүүдийг дагуулж хийх ёстой юм болов уу гэсэн бодол надад байгаад байдаг юм. Надад бол тодорхой тоон мэдээллүүд байгаад байдаг. Баруун бүс нутгаар 24 мянган тонн гурил орж ирсэн. 50 килограммын гурил 125-135 мянгатай байна гэдэг юм яригддаг байсан. Өнөөдөр 85 орчим мянган төгрөгтэй байгаад байх шиг байна. Тийм учраас Баруун бүс нутгийн гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээ 25 орчим мянган тонны асуудал байгаа юм уу гэсэн ийм жишсэн хүн амаараа тооцохоор нэг ийм тооцоолол гараад байдаг. Тэгэхээр зэрэг энэ асуудал дээр ер нь ямархуу бодлого цаашид барина гэж тооцоолж, энэ асуудлыг оруулж ирж байна вэ гэсэн ийм 2, 3 зүйл дээр их тодорхой хариулт авчихмаар байна.

Ц.Даваасүрэн: Хариулъя. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жилийн өвөлжилт, хаваржилттай холбоотойгоор, ялангуяа баруун бүсэд гурилын үнэ, тэжээлийн үнийн өсөлт өндөр явагдсан. Энэ юу вэ гэвэл баруун бүсэд газар тариаланг хөгжүүлээгүй байна л гэсэн үг. Хуучин 1990 оноос өмнө баруун бүсэд гол бааз суурь болж байсан Увсын Баруунтурууны аж ахуй өөрөө баруун бүсээ хангах зорилттой, гурилын үйлдвэртээ элеватортой, усалгаатай, иж бүрэн 40 гаруй мянган га талбай тариалдаг ийм томоохон аж ахуй байсан. Тэгэхээр энэ бүс нутагт хөрөнгө оруулах дэмжлэг зайлшгүй байна гэдэг нь үүгээр харагдаж байгаа юм. Нэгэнт нөхцөл байдал, үнэ өссөнтэй холбоотойгоор бүх татварыг чөлөөлсөн. Ямар эффект гарсан бэ гэж.

Би гурилын үйлдвэрийн үнүүдийг мэдэгдье. Алтан тариа гурил 2024 оны 5 сар яг 1 жилийн өмнө үйлдвэрийн үнэ 1 дүгээр гурил 1630 төгрөг байсан бол одоо 2025 оны 4 сарын 20-ны байдлаар 1500 төгрөг, Улаанбаатар гурил 2024 оны 5 сард 2100 төгрөг байсан бол одоо 4 сарын 20-ны байдлаар 2050 төгрөг, Өег гурил 2024 оны 5 сард 1740 төгрөг байсан бол одоо 4 сарын 20-ны байдлаар 1610 төгрөг. Ингээд голлох үйлдвэрүүдийнхээ үнийг аваад үзэхэд дундаж үнэ 2024 оны 5 сард 1802 төгрөг байж байгаад, өнөөдөр 4 сарын 20-ны байдлаар 1638 төгрөг буюу 1 дүгээр гурил 9,1 хувиар буурсан ийм үр дүнтэй байгаа. Үйлдвэрийн үнэ шүү дээ.

Тэгэхээр өнгөрсөн жилийн намрын ургацтай холбоотойгоор ургац боломжийн байсан. Нэлээн их хэмжээний импорт бас нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор гурил бол бууж болох хамгийн нийлүүлэлтийнхээ түвшинд очиж тогтвортой байдал хангагдсан. Одоо бэлэн гурил болон улаан буудайн нөөц бол энэ оны намрын ургац автал ямар нэгэн нийлүүлэлтэд доголдол үүсэхгүйгээр, хангалттай нөөц бүрдсэн байгаа.

Бүсийн хувьд өөр. Бүс болгон чинь ачаа тээврийн зардлууд орж байна. Нэг зүйлийг иргэд андуураад байгаа юм. Сая бол үйлдвэрийн үнэ шүү дээ. Үйлдвэрүүд маань ийм үнээр үйлдвэрлээд гаргаж байна. Хүнсний сүлжээ дэлгүүрүүдэд гол нэмэгдэл явж байгаа. 30-40 хувийн нэмэгдэл худалдаан дээр яваад байгаа юм. 30-40 хувийн нэмэгдлийн худалдаан дээр гурил маань өөрөө хямд үнэтэй, овор ихтэй бараа. Ачаа тээвэр дээр яваад байгаа юм. Тээвэрлэлтийн зардал байна. Энийг бас их сайн тооцох ёстой.

Дотоодын 1 дүгээр гурил Улаанбаатарт 2970 төгрөгөөр байгаа бол баруун бүсэд 2696 төгрөг гэсэн ийм үнэтэй байна. Хангайн бүсэд 2640, зүүн бүсэд 2554, төвийн бүсэд 2483 гэсэн ийм 5 бүсээр гарсан Үндэсний статистикийн хорооны мэдээлэл гарсан байна. 25 ... гурилын нийлүүлэлт, гурилын үнэ тогтвортой байх ийм бололцоо бүрдсэн гэдгээ хэлье.

Ц.Даваасүрэн: Хариулт хангалттай юу Батжаргал гишүүн. Тэгвэл дараа нь Ж.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би энэ асуудлыг бол ерөнхийдөө зүгээр Энхбаяр сайдад хэлэхэд бол дэмжиж байгаа. Тэгээд яах вэ дотроос нь 2, 3 зүйл асууя. Ер нь бол бид энд үндэсний үйлдвэрлэлээ дэмжилгүй яах вэ дээ. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ. Тэгэхдээ ер нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжлээ гээд бид их үнэтэй улс болно гэвэл хилийн цаана хямдхан, хилийн дотор үнэтэй. Ингээд бүр их олон жил явна гэвэл их сонин шүү. Одоо бид нар цементийг бол уг нь мөнгө өгөөд, хөнгөлөлттэй зээл өгөөд, хилээ 2, 3 жил хаагаад гэдэг юм уу, тэгээд дэмжихлээ. Тэгээд буцаад тэрийгээ тэр өрсөлдөх чадвартай болгоод, болчихлоо гээд бид хямдхан цемент хэрэглэх ёстой шүү дээ. Зорилго нь тэр биз дээ. Тэгээд гурил дээр бид хэзээ тийм болох юм бэ гэж.

Бид өрсөлдөх чадвартай болоод, хямд гурил хэрэглэдэг дэлхийд өрсөлдөх боломжтой болно гэж л дэмжлэг үзүүлж байгаа л гэж ойлгож байна. Яах вэ, сая бас тийм стратеги, геополитикийн талын юм ярьж байна л даа. Тэгээд тэрийг нь би сайн ойлгохгүй юм. Тэгэхдээ яах вэ эдийн засагч хүний хувьд бол зүгээр Энхбаяр сайд эдийн засаг талаас нь тайлбарлаж өгөөч. Бид ер нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжилгүй яах вэ. Гэхдээ одоо үндэсний үйлдвэрлэл маань үнэтэй бүтээгдэхүүн өгөөд байвал бид тэгээд л хилийн цаана хямдхан, хилийн дотор үнэтэй ийм Швейцар шиг улс болох юм уу. Швейцар бол арай өөр бодлого хэрэгжүүлдэг байх. Цалин нь үнэтэй, ДНБ нь өндөр, тэгээд бид чинь өөрсдөө тийм биш байж байж үнэтэй бүтээгдэхүүн хэрэглэдэг улс болчих вий.

Би бас хэлье гэж бодоод байсан юм. Ер нь бол олон зүйл дээр ингээд харж байгаа. Тэгэхдээ ер нь бодлого бол зөв. Гэхдээ тэгээд олон үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ, бүгдийг нь дотооддоо үйлдвэрлэдэг болно гэдэг бол бас нэг гүйцэхгүй асуудал л даа. Тэгэхээр ангилж ялгаж байгаа биз дээ. Тэр дээрээ сайн анхаарч байгаа байлгүй дээ гэж би бодож байна. Зүгээр яах вэ дотоод нарийн асуудлууд дээр нь сая тавьсан бодлого бол үр дүнгээ өгсөн гэж байх шиг шиг байна. Үр дүнгээ өгсөн. Одоо боллоо. Хил, гааль дээр татвартай болох юм байна гэж ойлголоо шүү дээ. Буцаад татвар авдаг болох юм байна гэж ойлголоо. Тэгээд яг татвар авдаг болоод бид нарт ямар үр дүн үзүүлэх вэ. Таны түрүүний хэлсэн тэр эцсийн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн гар дээр очих бүтээгдэхүүний үнэ буух юм уу.

Би яах вэ Эдийн засгийн байнгын хорооны дарга байхдаа наад гурилын асуудлаар чинь ҮАБЗ-өөс нэг даалгавар өгөөд, би холбоотой нь уулзаад нэлээн явсан юм. Бас тийм ариухан газрууд биш байна лээ шүү. Бас л том асуудлууд байдаг юм байна лээ шүү.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд хариулна. Тэр татвар тавьснаар манай үнэ буурах уу. Дэлхийн зах зээлийн үнэтэй ойролцоо байх уу л гэдэг асуулт байна.

Ж.Энхбаяр: Монгол Улсын хэмжээнд яг тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 9 гурилын үйлдвэр байна. Хүчин чадлын ашиглалт өнөөдөр 30 орчим хувьтай байна. Бид хүнсний хувьсга, Атрын 3 хөтөлбөрийн үр дүнд 2019, 2020, 2021, 2022 гээд онуудад үндсэндээ дотоодоосоо улаан буудайгаа бүрэн хангаад, 100 хувь эх орны үйлдвэрийн гурилаар ард иргэдээ хангадаг болсон. Энэ шийдвэртэй холбоотойгоор 1 жилийн дотор бид үйлдвэрлэлийнхээ 40 хувийг алдаад байна. Импортын бараанд алдаж байна гэсэн үг.

Бид өөрсдөө цөөхөн төрлийн барааг дотооддоо бүрэн эцсийн бүтээгдэхүүн болгож чадаж байгаа. Цөөхөн. Хүнсний хувьсгал зорилтын хүрээнд тодруулж хэлбэл 19 нэр төрлийн барааг л дотооддоо үйлдвэрлэе. Ургуулъя, тарья, бүтээе. Энэ бол ковидын сургамжтай холбоотой үүссэн нөхцөл байдал. Нийт хүнсний сагсанд 350 гаруй төрлийн бүтээгдэхүүн ард иргэд хэрэглэж байгаа. Энэ дотроос 19 нэр төрлийг л Монгол Улс дотооддоо тарьдаг, ургуулдаг, хангадаг байх нь үндэсний аюулгүй байдал, хүнсний баталгаат байдлыг хангана гэж энэ зорилго тавиад хэрэгжүүлж байгаа.

Нөгөө талаар бид улаан буудай маань стратегийн бүтээгдэхүүн. Цөөхөн бараа байдаг стратегийн бүтээгдэхүүн. Улаан буудайг 5 жил, 10 жилийн дараа тээрэмдээд, бүтээгдэхүүн хийхэд гурил болж чаддаг. Ер нь цорын ганц бүтээгдэхүүн дэлхийн хэмжээнд. Тийм болохоор дэлхийн улс орон болгон стратегийн аюулгүй байдлын нөөц болгож улаан буудайг нөөцөлж авдаг.

Улаан буудай бид хямдхан байлгана гэж хэлж чадахгүй. Япон Улс цагаан буудайгаа хамгаалдаг шиг Монгол Улс улаан буудайгаа хамгаалах ёстой. Бидний 1990-ээд онд авсан нээлттэй бодлогын нэг сургамж бий. Монголын газар тариалан үндсэндээ бүрэн уналтад орсон. Бүх талбай зэрлэг шарилждаа баригдсан. Нэгдэл сангийн аж ахуйнууд бүрэн задарч унасан. Үндсэндээ бид хүнсээ бусдаас гуйдаг болсон. Ингээд 15, 16 жил гаднаас гурил, тусламжаар улаан буудай авдаг. Төрийн тэргүүнүүд, Ерөнхий сайдууд гадаад айлчлалын хүрээнд заавал гурил, улаан буудай гуйдаг хэмжээнд очсон. Энэ гутамшигт байдлаас гарахын тулд 2008 онд Санжийн Баяр Ерөнхий сайдын Засгийн газар “Атрын 3 дугаар аян”-ыг эхэлж, бид ямар ч үнээр хамаагүй дотооддоо улаан буудайгаа тарьж, гурилаа эцэслэн үйлдвэрлэе гэж зорилт тавьсан. Ганцхан гурилын асуудал биш. Улаан буудай тээрэмдэхээр тэжээл үүснэ. Ингээд газар тариалан нь тогтворжоод эхлэхээр энэ таримлын үр дүнд гахай, тахиа, шувуу, өндөг, сүүний гээд бусад эрчимжсэн аж ахуйнууд олон 10-аар бий болж байгааг та бүхэн анзаарч байгаа байх.

Нөгөө талаар энэ хөдөө аж ахуйн салбарт Монгол Улсын 2 хүний 1 нь ажиллаж байна. 600 мянган хүн ажлын байраар хангагдаж байна. Тэр хөдөө, орон нутагт ажил хийх, орлоготой байх, амгалан тайван амьдрах нөхцөлийг энэ хөдөө аж ахуйн салбар л бүрдүүлж байгаа юм. Тэгэхээр энэ эдийн засгаас илүү нийгэм, улс төрийн их томоохон ач холбогдолтой бас салбар гэдгийг тэр талаас нь

хармаар байна. Зөвхөн эдийн засгаас харж үзсэн 1990-ээд оны дунд үеийн тэр шийдвэртэй холбоотой гарсан хохирол бол олон тэрбум, олон 100 тэрбумаар хэмжигдэх хохирол авсан шүү дээ бид. Тэгэхээр тэр алдаа, сүүлд ковидоор болсон хил хаах үед улс орон яаж тэсэж гарах вэ гэдэг бодлого энэ бүгдээс үүдэж дотоодын цөөхөн 19 нэр төрлийн барааг л дотроо хангаж бүтээе, энийгээ хамгаалъя гэж байгаа.

Энэ Евразид холбоотой хийх гэрээний хүрээнд ч бас энэ хэдэн барааг хамгаалах бодлого давхар явагдаж байгаа.

Ц.Даваасүрэн: Ж.Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Энхбаяр сайдаа дэмжиж байгаа. Маш сайн дэмжиж байгаа. Тэгээд айхтар дуу нь чанга гараад байх шиг байна. Тэгэхдээ би бол сайн дэмжиж байгаа гэдгийг ойлголоо.

Тэгэхдээ зүгээр тогтолцоогоо л жоохон эвдээд, наад хүмүүс чинь тэгээд наад үйлдвэрүүд чинь ер нь байнгын л төрийн дэмжлэгтэй ийм зүйл болоод, зүгээр энгийн байдлаар ажиллаж чадахгүй тийм байдлыг үүсгэхийг вий л гэж би болгоомжилж байгаа юм. Тэгээд л төрийн дэмжлэггүй бол ажиллаж чадахгүй ийм салбар бий болчих вий гэж. Тэр чинь өөрөө ер нь сул талтай шүү дээ. Та өөрөө мэднэ. Та бас Хүнс, хөдөө аж ахуйн сайд болчихоод энийг ярьж байгаа болохоос та эдийн засгийн хувьд бас маш сайн шүү дээ. Тэрийгээ жоохон дараад байх шиг байна. Тэгэхээр миний хувьд бол бас тэрийгээ аль алийг нь жоохон баланслаарай. Тэгэхдээ би энэ бодлогыг дэмжиж байгаа шүү. Асуулт асуусангүй. Үг хэллээ. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Ер нь манайхан чинь импортын татвараа хамгаалаад өгөхөөр газарт унасан үнээр түүхий эдээ авна. Эсвэл тэнгэрт хадсан үнээр бүтээгдэхүүнээ зарлана. Ноолуур дээр самнаж гаргана гээд ингээд хаагаад өгчихнө. Тэгэнгүүт газарт унасан үнээр малчдаас авах гээд, шулах гээд л хэтэрхий ашиг хөөгөөд л, тэрийг л Ганбаатар гишүүн хэлээд байна шүү дээ. Ингээд байдаг шүү. Бас боломжийн түвшинд явах хэрэгтэй л гэдэг санал. Бүх орон Орос Украйнаас бусад дийлэнх орон бол улаан буудай татвартай байгаа шүү дээ. Тэр түрүүн цагаан будааны татварын Энхбаяр сайд хэллээ. Тэгэхээр энэ зүйлийг анхаараач гэж байна. Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Төсвийн байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Үндэсний үйлдвэрлэлээ бол дэмжилгүй л яах вэ дээ. Дэмжих ёстой гэж үзэж байгаа. Тэгэхдээ үндэстнээ боддоггүй үндэсний үйлдвэрлэл байх ёстой юу гэдэг асуудал. Ер нь хэрэглэгч 1-д байх ёстой юм уу, үндэсний үйлдвэрлэл 1-д байх ёстой юм уу.

2-т яг одоо энэ эрх зүйн орчны бодлогын зохицуулалтуудаа хийчихсэн гэж үзэж байгаа юу. Баяжуулсан хүнсний тухай хууль, Тариалангийн тухай хууль, Хүнсний тухай хууль, лабораторийн асуудлууд нь яах юм. Энийгээ цэгцэрчихсэн гэж бодоод, буцаагаад энэ татвараа тавих гэж байгаа юм уу. Тэгээд өмнө нь би бүлгийн хурал дээр бас асууж байсан. Яг юунд найдаад гурилын үнэ өсөхгүй гэдэг хариултыг өгч байгаа юм бэ. Би бол эсрэгээр нь харж байгаа. Одоо ирэх 7 хоногоос эхлээд иргэд үнэтэй гурил хэрэглэж эхлэх юм байна.

Яагаад иргэдэд сонголтыг нь үлдээхгүй байгаа юм бэ гэдэг л асуудал. Заавал үндэсний үйлдвэрлэлээ дэмжих ёстой гээд дотоодын гурилаа үнэтэй ид гэдэг сонголтыг яагаад тулгаад байгаа юм бэ л гэдэг асуудал.

2-т зөвхөн баруун бүсэд зориулаад энэ шийдвэр гарчихсан юм шиг ийм ойлголт өгөөд байх юм. Тийм биш шүү дээ. Зудад зориулаад гарчихсан юм шиг юм яриад байх юм. Тухайн үед та хэвлэлийн өмнө гараад сүүлийн 5 жил гурилын үнэ тогтвортой байгаа гээд худлаа яриад байна лээ. Үгүй ээ үгүй, дэлгүүр ороод л харчих л даа. Захын дэлгүүр ороод л харчих л даа. Захын дэлгүүрээр ороод л тэр гурил ямар үнэтэй хэрэглэж байгааг нь та харчих л даа. Тэгээд хүн юм ярихаар дундуур ингээд таслаад байдаг. Асуултдаа хариулт авъя.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Их Хурлын гишүүн үнэн юм ярих ёстой. Би дандаа Үндэсний статистикийн хорооны улирал тутмын мэдээ дээр үнэ ярьж байгаа. Миний хариуцсан хүрээнд улаан буудайн тариалалт, үйлдвэрлэл миний эрхлэх асуудлын хүрээнд. Энэ бий болсон бүтээгдэхүүн газар зүйн байрлал, хотын байрлал, зайн алсаасаа ямар өртөг шингээд, хэрхэн борлоод, ямар бүтээгдэхүүн болж байгаа асуудал дараагийн асуудал шүү дээ. Хөдөө аж ахуйн сайдын хувьд улаан буудай таригдах ёстой, гурилын үйлдвэрлэлүүд тогтвортой нийлүүлэлт хийх ёстой.

1 дүгээрт нийлүүлэлт гэдэг маань олон янз. Бид хямд гээд Оросоос авч байна. Үндэсний үйлдвэрийнхээ 40 хувийг алдаад байна. Ийм маягаар бол удахгүй дотоодын үйлдвэрлэл чинь байхгүй болох нь. Ингээд газар бүтээгдэхүүн тушаах үйлдвэргүй болохоор газар тариалан чинь унана. Олон мянган ажлын байр алдана. Бэлтгэгдсэн инженер, техникийн ажилтан, боловсон хүчин алдагдана. Энэ салбарт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын, дэмжлэгийн атрын аян, хүнсний хувьсгал, хэрэгжүүлж байгаа бүх хөтөлбөр чинь үр дүнгүй болж хувирах гээд байна шүү дээ. Бүх юмны суурь нь газар. Газар юм тарьж ургаж байгаад, тэр зүйл чинь нэг бол мал амьтны тэжээл, гахай, тахиа, шувуу, өндөг, сүү болж байна. Нэг бол бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн болоод л явж байна. Энэ дээр болгоомжтой, маш болгоомжтой. Би бол аюулгүй байдлаа бодож байгаа юм.

1990 он, 2000 оны үеийн тэр эдийн засгийн бодлого буюу зах зээлийн горимд хаясны үр дүнд энэ салбар унасан. 60 жил бүтээсэн нэгдэл сангийн аж ахуй нь бүрэн задарч устсан. Асар олон өмч үрэгдсэн, хаягдсан. 1 дүгээр сургамж.

2 дугаар сургамж Ковид. Өвчин, дайн дажин энэ гадаад орчин чинь хүндрээд байна. Дэлхийн Улс орон болгон тарифын бодлогоор үйлдвэрүүдээ хамгаалаад, дотоод үйлдвэрлэлийн чадавх, ялангуяа хүнсний аюулгүй байдлаа бэхжүүлээд байна. Иймд Монгол Улс хийж чадаж байгаа хэдхэн зүйл байна шүү дээ. Мал аж ахуйд тулгуурлаад малаа, махаа боловсруулж байна. Арьс шир, ноос ноолуураа боловсруулах гээд “Цагаан алт” хөтөлбөр нь явж байна. Ингээд хүнсээ хангачих гээд “Атрын аян”, Хүнсний хувьсгал хөдөлгөөнүүд нь явж байна. Энэ нь нийлээд нийлээд 19 нэр төрлийн л бүтээгдэхүүн байгаа юм. Тэгэхээр энийг стратеги юм, аюулгүй байдал юм, тогтвортой байдал юм гэж ойлгоод бүгдээрээ дэмжээд л явмаар байна.

Цаана нь бусад сонголт байна шүү дээ. 300 гаруй төрлийн сонголт чөлөөт зах зээлийн горимоор явж байна. Евразитай холбоотой гэрээ хийх асуудал ахиад 350

гаруй төрлийн хүнсний болон хөдөө аж ахуйн түүхий эдийн бараа бүтээгдэхүүн Монгол Улсад татваргүй орж ирнэ. Өргөн хэрэглээний бараанд маш хямдрал үүснэ. Тоо эрс нэмэгдэнэ. Гэхдээ бид дотроо зайлшгүй авч явах ёстой юм бол тэр түүхэн 2 сургамж дээрээ тулгуурлаад улаан буудай, ингээд үр дүн гарсан энэ нэг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг энэ тодорхой хүнсний хэдэн төрлийн ногоо, мах махан бүтээгдэхүүнээ дотроо үйлдвэрлэе дээ. Бид нарын ганц чадах юм шүү дээ. Эцсийн бүтээгдэхүүн хийж байгаа цөөхөн хэдэн төрөл байгаа юм. Ноолуураа эцсийн бүтээгдэхүүн болгож чадаж байна, ноосоо чадаж байна, арьс ширээ хийж байна. Энийгээ жоохон сайжруулчихъя л гэж зорьж байгаа зүйл шүү дээ. Тэгэхээрээ тэр өнцгөөс нь таныг иргэдийн хямд, хүртээмжтэй байдлаар хангах гээд байгааг ойлгоод байна. Тэрний цаана чинь аюулгүй байдал гэдэг юм гарч ирээд байгаа юм. Үнэхээр айтхар сургамж авсан шүү дээ.

Хэрвээ Ковид ахиад 1 сар үргэлжилсэн бол бид нар картын бараанд шилжихээс аргагүй байсан. Картын бараанд орох хэмжээний хүнсний хангамж тийм сул дорой ийм бодит байдал шүү дээ. Бүгдийг импортод даатгачихсан. Хил хаасан байхгүй. Тэгэхээр тэр сургамжийн үүднээс энэ ажил явж байгаа гэдгийг л ойлгоод өг л дөө.

Ц.Даваасүрэн: Баярбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Баярбаатар: Үндэсний үйлдвэрлэлээ дэмжихгүй байгаа зүйл ерөөсөө энд байхгүй байгаа юм миний санаа. Дэмжиж байгаа. Тэгэхдээ яг гурилын салбар дээр чинь өнөөдөр зах зээлийн систем үйлчлэхгүй байгаа шүү дээ. Ерөөсөө л халамжийн салбар болчихсон шүү дээ. Стратегийн бүтээгдэхүүн мөн. Тэгээд яагаад энэ гурилын үйлдвэрүүд чинь өөрсдөө эргээд иргэдээ бодохгүй байгаа юм бэ л гэдэг асуудал байгаа шүү дээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хөтөлбөрүүд өнөөдөр дунд шатандаа очоод бүгд л саармагжиж байгаа шүү дээ. Энэ бол үнэн. Одоо би бол энэ асуудал дээр цаашаа үргэлжлүүлээд ярина. Явна. 212 тэрбум төгрөгийг сүүлийн 3 жилд гурилын үйлдвэрүүдэд олгосон. Тэгээд асуудал болохоор тариаланчдыг урдаа бариад, асуудлаа шийдүүлсний дараа тариаланчдыг тойргоос гаргаад л хаячихдаг л юм байна лээ шүү дээ. Өнөөдөр та хэд тэрний оронд хөрсөө улсаас борддог больё гээд орж ирсэн бол энэ бол бодит шийдвэр болох байсан шүү.

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Батболд гишүү.

Р.Батболд: Ер нь бол гурилаа бид нар чинь өөрсдөө стратегийн хүнсний бүтээгдэхүүн л гэж ойлгоод байгаа. Ер нь болохоо байхад Монголчууд чинь гурил, махтайгаа байж байвал хэсэг үзнэ дээ л гэж ярьдаг ард түмэн шүү дээ тээ. Тэгэхээр энэ салбараа бид нар хамгаалж авч үлдэх хэрэгтэй байх. Зүгээр би яамнаас 1 асуулт асуугаадахъя. Тэгээд хариултыг авчхаад эргээд, дахиад 1 минут асууя.

Юу гэхээр одоо бид нар импортын татварыг тэглэснээрээ хэчнээн аж ахуйн нэгжийг унагаачхав. Хэдэн гурилын үйлдвэр чинь хүчин чадал нь арай буураад ажиллачхав. Хөдөө аж ахуйн салбарын тариалангийн хэдэн аж ахуй энэ улаан буудай тарихаа больчихов гэдэг ийм судалгаагаа хэлээд өгөөч. Тэгээд жоохон үндэслэлтэй ярихгүй бол зүгээр би бол стратегийн бүтээгдэхүүн гэдгээр нь

хамгаалж авч үлдэх л ёстой гэж ойлгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр салбар яаж унаад байна гэдгийг хэлээд өгөөч. Эргээд босгоход бас ямар хугацаа хэрэг болох юм. Хэрвээ бүр уначихлаа гэж бодоход.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үйлдвэрлэл 40,9 хувийг алдсан. Үндсэндээ 100 хувь хангаж байсан, үйлдвэрлэж байсан үйлдвэр одоо 60 хувьд орсон. 40 хувь импорт. Үүнтэй холбоотойгоор тариалалт унасан. Ургац дагаж унасан. Улаан буудайн импорт бэлэн гурилын импорт, тэжээлийн импорт нэмэгдсэн. Үнийн асуудал яригдаад байгаа нь яагаад үнэ өсөхгүй гэж хэлээд байна гэнэ. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа 9 үйлдвэрт 160 мянган тонн улаан буудай хүлээж авсан. 2024 оны ургацаас. Үүнээс 116,9 мянган тонн улаан буудай бэлэн байна. 25,3 мянган тонн гурил агуулахад хураалттай байна. 8,2 мянган тонн хивэг байна. Дээрээс нь хөдөө аж ахуйн корпорацад 45 мянган тонн улаан буудай бэлэн байна. Энэ нь шинэ ургац хүртэл дотоодын гурилын үнийн тогтвортой байдлыг бүрэн хангана. Дээрээс нь импорт 2024 онд 64,2 мянган тонн бэлэн гурил орж ирсэн. Энэ маань тухайн үеийн тооцоолоод тэр баруун бүсийн дутагдлыг арилгахаас үндсэндээ 3 дахин их ороод ирчихсэн. Тэжээл нь 1,5 дахин буюу 65 мянган тонн ороод ирчихсэн буюу өнөөдөр импортын бараа мөн маш их. Зөвхөн 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 17 мянган тонн бэлэн гурил орж ирчхээд байж байна.

Тэгэхээр үнэ бол өсөх ямар нэгэн бололцоо эрсдэл байхгүй. Тогтвортой байдлаа хангаж чадна. Тэгээд тэр жилийн өмнө байсан үнийн зохицуулалт дээр бид бас гурилын үйлдвэрүүдтэйгээ, Тариаланчдын холбоотойгоо хамтраад зохион байгуулалт хийгээд, бүсийн ялгааг эвтэйхэн аваад гарчих байх. Гол нь энэ зохицуулалтыг өмнө нь Засгийн газар их шуурхай хурдтай хийдэг бололцоотой байсан юм. Баруун тал дутвал төвөөсөө нийлүүлэлтээ хийгээд, баруун талдаа боомтоо нээгээд ингээд зохицуулах эрхээ нефть бүтээгдэхүүн дээр чинь засаг тийм эрх байдаг. Хойно дутагдвал дотроо татварын буултаар урамшуулаад, хямдраад ирвэл онцгой татвараа нэмээд, нийлүүлэлтээ тогтворжуулна гэдэг шиг яг үүн шиг улаан буудайг ингээд тогтворжуулах эрхээр л засаг авчихъя гээд байгаа юм. Тэгэхгүй хууль болгоод түгжчихээр энэ процедур явсаар байгаад бүтэн жил болчихоод, хэрвээ улаан буудайн тариалалт 5 сарын 1-ээс эхлэх гээд хүлээгээд байдаг, шийдэл байхгүй. Хэрвээ улаан буудайн энэ асуудлыг шийдэхгүй бол улаан буудайн тариалалт өөр таримал руу шилжих гээд байгаа юм.

Ингээд өөр таримал тариалалт нь шилжээд явчих юм бол тэрийг дагасан технологи, техникийн өөрчлөлт гээд ерөөсөө айхтар зүйл явчихдаг. Тэгээд энийг эргэн жолоог нь эргүүлнэ гэдэг бол 10 жилээс наашгүй ажил болчихдог.

Ц.Даваасүрэн: Тодруулъя.

Р.Батболд: Энэ жилийн тариалалтын хэмжээ хэчнээн га-д улаан буудай тарих гээд байна. Тэр нь энэ жилийнхээ хэрэгцээг хангаж чадаж байна уу, чадахгүй байна уу. Энийг тодруулж асуугаадахъя.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд аа, нөгөө дампуурсан аж ахуйн нэгжүүд байгаа юу. Саяын импортын татварыг байхгүй болгосноор гэдэг дээр бас нэмээд хариулчхаарай.

Газар тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд хүндрээд хаалгаа барьсан юм байна уу гэж асуугаад байна лээ шүү дээ.

Ж.Энхбаяр: Гол гурилын үйлдвэрлэл 40 хувиар унана гэдэг маань үндсэндээ дунд зэргийн үйлдвэрүүд “Дорнод гурил”, “Хөвсгөл Алтантуга” нөгөө хэд нь бас нэг үйлдвэрүүд үндсэндээ үйлдвэрлэлээ зогсоочихсон. 5-6 үйлдвэр бол үндсэндээ ... тариаланчид бол харьцангуй гайгүй. Яагаад гэвэл ноднин тарьчихсан, тариад тушаалт хийчихсэн. Газар тариалангийн компаниуд гурилын үйлдвэрүүдээсээ борлуулалт хийгдээгүй болохоор мөнгөө авч чадаагүй. Мөнгөний ийм дамжсан гинжин өр үүсчихэд бас амаргүй байгаа юм.

Тэгэхээр энэ жилийн шинэ тариалалт эхлэх гэж байна. Тэгэхээр энэ жилийн төлөвлөлтөөр бид 310 мянган га-д улаан буудай тарьж, 414 мянган тонн үр тариа авна. Төмс 20 мянган га-д тарьж, 285 мянган тонн төмс авна. Хүнсний ногоог 19 мянган га-д тарьж, 300 мянган тонн хүнсний ногоо, 144 мянган га-д тэжээлийн ургамал тарьж 389 мянган тонн тэжээл, 103 мянган га-д тосны ургамал тарьж .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Дутуу хариулсан учраас тодруулж болно. Батболд гишүүн.

Р.Батболд: Тэгэхээр яах вэ, би зүгээр бас нэг ийм л юм ярих гээд байгаа юм. Үндэсний үйлдвэрлэлээ бид нар дэмжээд байгаа юм. Одоо энэ санхүүгийн асуудлуудыг нь ингээд яриад байна л даа. Энэ чинь бас үнэн байхгүй юу. Бид нар дандаа төрөөр угжуулсан ийм үндэсний үйлдвэрлэлийн салбаруудтай болчих гээд байна уу даа гэдэг л юм би Хөдөө аж ахуйн яаманд байнга хэлээд байгаа юм. Одоо энэ жил бас л нөгөө “Цагаан алт” гээд ноолуур авч байна гээд л баахан мөнгө гаргаад л байдаг, гаргаад л байдаг, бас л миний яриад байгаа тэр давтан зээлдэгч нь хэд байгаа юм. Эд нар чинь үйлдвэрүүд нь өөрсдөө санхүүгийнхээ чадавхыг дээшлүүлье гэж ажилладаг юм уу, ажилладаггүй юм уу. Дандаа төрөөс мөнгө аваад яваад байх юм уу. Одоо гурилын үйлдвэр гэхээр бас л адилхан тариаланчид нь бас ингээд л угжуулаад л яваад байх юм уу. Яаж энэ санхүүгийнхээ чадавхыг бас сайжруулах ёстой юм. Энэ дээр ер нь яам яг ямар бодлоготой яваад байгаа юм бэ л гэж яриад байгаа юм л даа. Тэгээд энийг бас хариулаад өгвөл сайн байна.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн салбар Улсын Их Хурлын томоохон дэмжлэгийг авч байгаа. Үнэн. Бидний зорилго бол уул уурхайгаас хэт хамааралтай, үндсэндээ 96 хувийн хамааралтай эдийн засгаа олон тулгуурт тулгах том зорилтыг л энэ Засгийн газар, энэ Их Хурал дэвшүүлсэн шүү дээ. Тэр хүрээнд энэ “Цагаан алт” хөтөлбөр, “Атрын 4 дүгээр аян”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо” гээд энэ бүх хөдөлгөөнүүдийг чинь хоорондоо уялдаатай хөдөө аж ахуйн салбараа босгож ирэх зорилготой. Уул уурхайн энэ мөчлөгийн таатай үеийг ашиглаж, тодорхой хэмжээнд хөдөө аж ахуйн салбараа бэхжүүлж босгоё гэдэг л зорилт. Энэ бас их богино хугацаанд үр дүн гарах худалдаа наймаа хийх шиг ажил биш л дээ. Бас хүн сургах технологи, газар, хөрөнгө оруулалт гээд хугацаа шаардана.Тэгэхээр энэ бол 2028 он хүртэл саяын нэр дурдсан хөтөлбөрүүд хэрэгжих ёстой.

1 зүйл байгаа засгийн .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут нэмээд өгчихье Энхбаяр сайд 1 минут.

Ж.Энхбаяр: Баярлалаа. Салбарын сайд бол Улсын Их Хурлын баталсан бодлого, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа шүү дээ. Энэ саяын дурдсан хөтөлбөрүүд маань бүгд Улсын Их Хурал, Монгол Улсыг хөгжүүлэх дунд хугацааны болон урт хугацааны 2050 бүх хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд суусан бодлогын хүрээнд л хэрэгжиж байгаа зүйл. Үүнээс гадуур ямар нэгэн арга хэмжээг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэггүй шүү дээ. Тэгэхээр Их Хурлын баталсан тэр бодлогыг л бид хэрэгжүүлж байгаа.

Ц.Даваасүрэн: Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Өглөөний мэнд хүргэе. 2024 онд баталсан гурилын импортыг тэглэх асуудал бол бас үр дүнгээ өгсөн гэж харж байгаа. Манай Монгол Улсын зах зээл дээр гурилын үнэд бас тогтворжсон асуудлууд байна. Тэгэхдээ би энэ ажлын хэсгийн дүгнэлттэй холбоотой асуудал дээр одоогийн нөхцөл байдал дээр хэд хэдэн асуулт байна.

Одоо ингээд импортоо буцаагаад сэргээх гэж байна л даа. Энэ нөхцөл байдал дотоод үйлдвэрлэлээ дэмжиж байна. Эерэг тал нь. Сөрөг талд нь бол гурилан бүтээгдэхүүний гурил болон гурилан бүтээгдэхүүний үнэ өсөх нь гэсэн байгаа. Өсөх хандлага ажиглагдана гэж. Яг үндсэндээ 2015 оноос 2024 он хүртэл гурилын үнэ 2,5 дахин өссөн байна. Тэгээд сая таны өгсөн мэдээлэл дотор болохоор яг импортоор орж ирэх гурилын татварыг тэглээд өгөнгүүт 1кг тутамдаа манай үйлдвэрлэгч нар гурилаа 200 хүртэлх төгрөгөөр бууруулчихсан байгаа байхгүй юу. Өнөөдрийг хүртэл ингээд хадгалаад явж байна. Тэгэхээр энэ үнэ өөрөө яг тийм бодит үнэ байсан юм болов уу. Энэ гурилын өсөлт чинь өөрөө бодитой юм уу гэдэг нь эргэлзээ төрүүлэхээр ийм дүгнэлтүүд харагдаж байгаа. Тэгэхээр бид бүхэн энэ гурилын үнэтэй холбоотой асуудал дээр хөндлөнгийн янз бүрийн судалгаа хийж үзсэн. Энэ өртөгтэй холбоотой асуудал дээр судалгаа хийж үзсэн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт байдаг юм уу. Яг хэр бодитой байгаа юм бэ гэдэг тал дээр надад нэг хариулт өгөөч.

Ер нь цаашдаа энэ импортын асуудал эргэж сэргэж орж ирснээрээ татвартай холбоотой бас эргэж орж ирснээрээ гурилын үнэ өсөх юм уу 1 дүгээрт.

2 дугаарт нь ажлын хэсгийн дүгнэлт дээр хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэлээс сэргийлнэ гэхсэн байгаа. Энэ татварын асуудал эргэж сэргэснээрээ. Тэгсэн чинь манай Монгол Улсад орж ирж байгаа, бас тариалж байгаа улаан буудайн 241 дээжээс судалгаа аваад үзсэн чинь 80 дээж буюу 33 нь шаардлага хангаагүй гэсэн судалгаа гарчхаж. Тэр нь 17,5 хувь нь гадаад, 82,5 хувь нь дотоодын үрийн дээж байна. Тэгээд энэ чинь тэгээд аюулгүй байдлыг хангаж чадна гэж байгаа зорилготой чинь хэр нийцэж байгаа юм бэ. Энэ дээр хариулт өгөөч.

3 дугаарт нь хүнс ХААЯ-аас газар тариалан эрхлэгч нар, гурилын үйлдвэр эрхлэгч нарт дэмжлэгүүд үзүүлдэг. Яг ямар ямар бодит дэмжлэг үзүүлдэг юм бэ. Яг ийм ийм дэмжлэг үзүүлсэн, тэр нь тэдэн төгрөг зарцуулсан гээд. Үүний чинь тэгвэл үр нөлөө гарсан юм уу. Яаж гарсан юм. Тухайлах юм бол үнэ дээр. Гурилын

үнэ дээр, дээрээс нь чанар дээр ямар ахиц гарсан юм бэ. Яг энийг тоо баримттайгаар надад нэг хэлж өгнө үү. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: 3 тодорхой асуулт асууж байна. Хариулъя. Энхбаяр сайдын микрофон.

Ж.Энхбаяр: Газар тариалангийн салбарыг сэргээхийн тулд үе үеийн Их Хурал, Засгийн газар бодлогын арга хэмжээг тасралтгүй авч ирсэн. 2008 оноос хойш энэ бодлого өнөөг хүртэл тасраагүй. Гурилын чанар тэр “Атрын 3 дугаар аян” эхэлсэн 2008 оноос хойш эрс сайжирсан. Манай гурилын үйлдвэрүүд дэлхийн нэг номерын Швейцар, Туркийн хамгийн орчин үеийн төхөөрөмжөөр үйлдвэрлэлээ 100 хувь явуулж чадаж байгаа. Чанар бол хойд хөрштэй зүйрлэхгүй шүү дээ. Илүү болж чадсан. Энэ нь өнөөдөр хэрэглээнд гарч байгаа олон төрлийн гурил, гурилан бүтээгдэхүүнүүдийн чанар. Гурил маш олон төрлөөр үйлдвэрлэгддэг болсон. Олон төрлөөр баяжуулагддаг болсон. Сонголт ихтэй болсон. Зөвхөн 50, 70 килограммаар шуудаатай гурил биш өнөөдөр маш олон төрлийн үйлдвэрлэлийн технологид тааруулсан олон хэлбэрээр үйлдвэрлэх чадалтай болж чадсан. Энэ бол баталгаатай хэлнэ.

Улаан буудайн үйлдвэрлэл дээр чанарын ахиц эрс гарсан буюу бид улаан буудайн ургац жил ирэх тусам тогтвортой нэмэгдүүлж чадаж байгаа. Дэлхийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг газар тариалангийн салбар нэвтрүүлж, ашиглаж, эзэмшиж байгаа. Газар тариалангийн салбарт бүтээмж, таримлын нэр төрөл олшроод ирэхээр өнөөдөр энэ гахай, тахиа, шувуу, сүү гээд бусад өндөг гээд эрчимжсэн аж ахуйнууд олон арваар бий болж байгаа нь газар тариалангийн үйлдвэрлэлийн өсөлттэй шууд холбоотой. Чанарын үзүүлэлт. Үнэ. Улаан буудай бол дэлхийн зах зээлээр биржийн үнэтэй ийм бараа буюу тухайн жилийн дэлхийн цаг уурын байдал ургацын хэмжээтэй тогтдог. Нүүрстэй адилхан, алттай адилхан өсөж л байдаг, унаж л байдаг. Ямар ч түвшинд бид дотооддоо тодорхой хэмжээний нөөцөө өөрөө тарьж, ургуулж, хадгалж, болзошгүй эрсдэлийг даван туулахад бэлдэж байх ёстой. Тэр талаас нь харах ёстой.

Бид Улсын Их Хурлын тогтоолоор жил бүр бүр 100 мянган тонн үр тариа авах ёстой боловч төсвийн хязгаарлагдмал байдлаас болоод энийгээ авч чадахгүй л яваад байгаа. Уг нь жил бүр улс 100-аас доошгүй мянган тонн үр тариа авч хадгалж байх учиртай. Тэгж аюулгүй байдлынхаа юмыг бол хангаж байх учиртай. Тэр зүйл дээр бас төсөв хөрөнгийн асуудал холбоотой юм гардаг. Тэгэхээр дэмжлэгийн нарийн ширийн 2008 оноос хойших бүх тоог би танд өгнө. Тэрийг яривал их урт тоо гарна.

Түрүүн Баярбаатар гишүүн хөрсөө анхаар гэж. Одоо 2025 оны гол бодлогын өөрчлөлт бол үндэсний үйлдвэрт тонн тутамд тушаасан улаан буудайд урамшуулал болгож 80 мянган төгрөг өгдөг байснаа больж байгаа. Энийгээ бордоо болгож газартаа шингээх ийм бодлого болж байгаа. Бодлогын их том өөрчлөлт бол газар бордоно. Улаан буудай тарьсан, тариалалт хийсэн тэр газарт нь тооцуулан индексжүүлэлтээр бордоогоор урамшуулах бодлого. Яагаад гэвэл газар бол төрийн өмч. Тэгэхээр тэр газрын хөрс үржил шимээ сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

Тэр дээж гэж байна. Ажлын хэсгээс гарсан ямар экспертүүд яаж дүгнэлт гарсныг би мэдэхгүй байна. Би энэ материалтай танилцаагүй. Тэгэхээр ажлын

хэсгээс асуух биз. Би яг энэ салбар хариуцаж байгаа, бодлого барьж байгаа хүний хувьд бүх үзүүлэлтээр дандаа дээшилж байгаа гэдгийг л хэлэх гэж байна. Экспорт ч нэмэгдэж байгаа. ДНБ-д эзлэх хувь хэмжээ ч нэмэгдэж байгаа. Энэ салбар дахь ажлын байр ч нэмэгдэж байгаа. Уул уурхайнхаас ангид эдийн засгийг бий болгох гол бодлого бол энэ хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл. Эндээ жоохон бодлого гаргаж, урт хугацааны тогтвортой байх хэрэгтэй байна.

Ц.Даваасүрэн: Тодруулах юм уу. Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: 4 минутын хугацаанд хариулт авах гэж хариулж байгаа хүмүүс нь л тойруулж давхисаар байгаад л таарчих юм сайд аа. Би тодорхой л асуулт асуугаад байна танаас. Тэгээд тодорхой хариулаад өгчихгүй дэвэн дэлхийн юм ярьсаар байгаад дуусгаад байх юм та. Би тодорхой асуулт асуусан. Та бүхний оруулж ирсэн материал дээр л би ажиллаад, асуудлуудаа тавиад байгаа юм. Үгүй ээ, би зөв ойлгоно гэж юу гэсэн үг юм. Энэ дээр чинь байна шүү дээ. 241 дээжийн шинжилгээ хийсний 80 дээж нь буюу 33,6 хувь нь шаардлага хангаагүй байна гээд гараад ирчихсэн байна шүү дээ. Энэ дүгнэлт дээрээ уншаарай та. Та угаасаа тэрийг чинь шинжилж судалгаа хийдэг хүн юм уу. Хөндлөнгийн энэ судалгааны байгууллагуудын дүнг та өөрөө хүлээн зөвшөөрөх ёстой. Магадлах ёстой юм байгаа биз дээ. Хэрүүл хийгээгүйг би танаас асуултын хариулт авах гэсэн юм. Тэгээд 4 минутын хугацааг тойруулж давхисаар байгаад өнгөрөөдгөө болимоор байгаа юм.

Ц.Даваасүрэн: Санал уу. Асуусан юм уу. Тодорхой хариул гээд. Энэ ингэсэн юм байна. Энэ Их Хурлын даргын байгуулсан Баярбаатар даргатай ажлын хэсгийн санал, дүгнэлт тараагдсан юм байна. Энэ санал, дүгнэлттэй холбогдуулаад асуугаад байгаа юм байна л даа. Тэгэхээр энэ санал, дүгнэлтийг та нарт хүргүүлсэн юм уу. Хүргүүлсэн бол үүнтэй санал нэг байгаа юм уу, үгүй юм уу гэдэг тайлбарыг л сонсох гээд байхгүй юу. Тэрнээс биш таны мууг үзэх гээд байгаа ч юм бас биш л юм байна. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: 1 дүгээрт энэ ажлын хэсгийн дүгнэлттэй танилцаагүй. Надад өгөөгүй ээ. Ямар мэргэжлийн экспертүүд яаж хийснээ мэдэхгүй. Асуудлыг хандахдаа салбарыг урт хугацаанд нь хараач. Энэ 3-5 жил, сүүлийн 2008 оноос хойш улаан буудайн чанар, гурилын чанар, энэ салбарын өсөлтийг хараад сайн, мууг дүгнэх нь зүйтэй болов уу.

Тэр хаанаас ямар дээж аваад, яаж гаргасныг нь би мэдэхгүй байна. Улаан буудай жил жилийн ургац өөр. Хур бороо, нар чийг, хөрсний агууламжаас шалтгаалан тэр доторх үзүүлэлтүүд дандаа өөрчлөгдөж байдаг. Нэг уулын ар, өвөр 2 өвөр гардаг. Тэгээд юуг нь муу гэж үзээд, юу нь муу байсан юм. Жишээлбэл Шилэнцэр нь муу байсан юм уу, хатуулаг нь муу байсан юм уу, цавуулаг нь муу байсан юм уу. Энэ чинь олон үзүүлэлт. Энэ чинь үйлдвэрлэлд хэрэглэж болохгүй муу гэсэн үзүүлэлт биш шүү дээ.

Ц.Даваасүрэн: Ер нь байна шүү дээ ийм л юм байна лээ. Бид нар бас нэг жоохон бодолтой хандахгүй бол. Та нар яг ингээд дэлгүүрт орвол ганц гурил өссөн биш шүү дээ. Энэ ажлын хэсгийн дүгнэлт дээр гурилын үнэ 2020-2024 онд 5 жилийн хугацаанд 2,5 дахин өссөн гэж байгаа байхгүй юу. Ганц гурилын үнэ биш. Бүх юмны үнэ. Тэр бензиний үнэ, суурь үнүүд, цахилгаанууд нь өсөөд ирэхээр бүх л юмны үнэ өснө. Тэрнээс гурилын үнэ ганцаараа ингээд өсчихсөн юм шиг яриад

байгаа байхгүй юу. Энэ бас жоохон буруу шүү. Бүх юмны үнэ 2-3, тэрнээс дээш өссөн байгаа. Батлут гишүүн 1 минут.

Д.Батлут: Энхбаяр сайд аа, би таны мууг үзэх гээд байгаа юм биш. Бас энэ салбарыг дэвсэлчих гээд байгаа юм биш. Ерөнхийдөө бид нар аль аль талаас нь харж, зөв байдлыг л бий болгох гэж байгаа санаа шүү дээ. Тэгээд урт хугацаандаа аливаа асуудлыг харах нь зүйтэй л байх. Тэгэхдээ жижиг сажиг зүйлүүдийг хаяхгүйгээр урт хугацаагаар харна гэвэл тэр жижиг зүйлүүд чинь нэгдсээр байгаад том эрсдэлийг бий болгодог юм шүү гэдгийг би танд сануулж хэлмээр байна. Зүгээр яах вэ, Улсын Их Хурлын даргын 59 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг танай яамнаас оруулж ирсэн энэ дүгнэлт, мэдээлэлтэй л харьцуулж уншиж байгаад л би саяын асуултуудыг асууж байгаа юм. Тэгээд та миний асуусан асуулт дээр бичиж аваад, бүр тодорхой хариултуудыг бичгээр ирүүлээрэй гэж хүсэж байна. Танай яамнаас тухайлбал газар тариа хэрэглэгч нарт, гурил үйлдвэрлэгч нарт ямар ямар бодит дэмжлэгүүдийг үзүүлсэн юм. Тэрнээс ямар үр дүнгүүд гарсан юм. Үнийн хувьд, чанарын хувьд. Энэ тал дээр та надад мэдээллүүдийг яаралтай ирүүлээрэй гэж хүсье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэрийг нь ирүүлчихнэ биз. Тэгэхээр бичгээр явуулчихгүй юу. Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Би энэ гурилын импортын татварыг ер нь тэглэснийг буцаагаад тавих гэж байгаа бол дэмжиж байгаа зарчмын хувьд. Яагаад гэхээр гурил бол өөрөө бас ард иргэдийн яг амьдрал, өрхийн гол хэрэглээнд нөлөөлж байгаа, инфляцад нөлөөлж байгаа ийм өргөн хэрэглээний бүтээгдэхүүн мөн. Тэгэхдээ бид нар гурилынхаа үнийг тохиромжтой үнэд хүргэнэ гээд гаалийн татвараа тэглээд, үндэсний үйлдвэрлэлүүдээ хүнд байдалд оруулж болохгүй. Ер нь ганцхан гурил биш. Цемент дээр бас ийм байдал бий болгосон. Бид нар үйлдвэрлэгч улс байх юм уу, хэрэглэгч улс байх юм уу гээд л. Үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжье гээд л төр бодлого явуулдаг. Тэгээд 1 талаараа дэмжээд нөгөө хувийн хэвшлүүд нь баахан гадна, дотноос урт хугацааны зээл аваад, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлээд явж байтал нөгөө талд нь төр нэг өдөр гэнэтхэн гаргадаг. Ямар ч урьдчилж мэдэгдсэн юм байхгүйгээр шууд гаалийн татварыг тэглэдэг. Тэгэхээр ийм байдлаар төр засаг бодлого нь тогтвортой бус, гэнэтийн байдлаар ийм шийдвэр гаргаж болохгүй л дээ. Тэгээд энэ гурилын үнэ тодорхой хэмжээнд өслөө гээд өмнө нь гурилын компаниудад улаан буудайн бас тариалалт дээр хөнгөлөлттэй зээл өгсөн гээд буруутан болохоороо бүгдийг нь хувийн хэвшил рүүгээ дайрч ирээд байдаг. Өнгө аяс нь. Тэгээд үүний бодлогыг дандаа төр өөрөө гаргаж явж байгаа шүү дээ. Тэгээд төрөөс олгож байгаа хөнгөлөлттэй зээлүүд, дэмжлэгүүдийн үр дүн ямар байх вэ гэдгийг оновчтой байсан уу, үгүй юу гэдгийг бас дүгнэж ярих ёстой. Тэгээд энэ дээрээ бас тухайн шийдвэрээ гаргаад, энэ гурилын компаниудад тодорхой хэдэн компанид өгсөн байгаа шүү дээ. Өнөөдөр цөөхөн хэдэн гурилын компанитай болсон гээд байгаа. Тэрийг чинь цөөхөн болгохыг нь бас төр өөрөө хийсэн юм билээ. Төр өөрөө тодорхой хэдэн компаниудад зээл өгөөд, олон компани өрсөлдөх боломжийг нь хаагаад, зарим нь дампуурч хаалгаа бариад, нөгөө хэд нь бас хоорондоо тохиролцож үнээ нэмдэг ийм асуудлууд бас үүссэн байна гэж дүгнэсэн байсан.

Тэгэхээр нэгд импортын татвараа тавьчихлаа. Тэгэхээр буцаад энэ компаниуд хоорондоо бас тохиролцоод үнээ нэмэхгүй байх гэсэн баталгааг яаж та харж байгаа вэ. Хангах вэ.

2-т энэ Өрсөлдөөний тухай хууль монополын эсрэг ямар арга хэмжээнүүд хууль, эрх зүйн зохицуулалт хийж давхар авах вэ. Тэгэхгүй бол өрсөлдөөн бий болгож байна гээд импортыг нь тэглээд, гаднын компаниар гаднын бүтээгдэхүүнээр бид нар дотоодын зах зээлийн асуудлаа шийдүүлээд явна гэдэг бол буруу жишиг л дээ. Тэгэхээр энийг дотооддоо яаж шийдэх юм бэ гэдэг 1 дэх асуулт байна.

2-т энэ хөдөө аж ахуйн салбар тэр тусмаа хөнгөлөлттэй зээл, дэмжлэгүүд асар их олгож байгаа. Өнгөрсөн хугацаанд ч энэ гурилын компаниудад олгосон. Энийг яаж оновчтой болгох вэ. Энэ оновчтой болоод явах юм бол энэ үнэ чинь өөрөө тогтворжоод, төрийн чиглэж байгаа бодлогод нийцээд явах ёстой шүү дээ. Энэ боломжийг та яг яаж харж байгаа вэ гэсэн ийм 2 асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Би энэ монопол үгсэн хуйвалдсан гэдэгтэй санал нийлэхгүй. Энэ тийм боломжгүй салбар. Олон мянган тариаланчид улаан буудай тарина буюу тариаланчид үгсэн хуйвалдах ямар ч бололцоо байхгүй. Энэ өөрийн эзэмшиж байгаа талбайн хэмжээнд хөрөнгө оруулалт буюу техникийн хүчин чадал нь өөр өөр сууж байгаа. Ургамал хамгааллын бодис, бордоо, шатахуун, техник гээд олон нийлүүлэгч оролцсон.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ үгүй тариаланчдыг хэлээд байгаа биш. Энхбаяр сайд аа байж бай. Ямар асуудал үүссэн гэхээр газар тариалан эрхлэгч, үйлдвэрлэгч 2-ын хооронд бөөн маргаан болсон. Тэрийг яриад байгаа байхгүй юу. Биднээс хямдхан авчхаад, өндөр үнээр зарж байна гээд. Тэрийг яриад байгаа байхгүй юу.

Ж.Энхбаяр: Тэгэхээрээ улаан буудайн жил жил ургац чанар өөрөө гардаг. Эцсийн эцэст бүтээгдэхүүн чанартай байх ёстой. Тэр бүтээгдэхүүн чанартай байхын тулд улаан буудай чанартай байх ёстой. Тэгэхээрээ гурилын үйлдвэрүүд бас тариаланчдадаа шаардлага тавьдаг. Тэгэхэд зарим жил хур тунадас ихтэй жил улаан буудайн цавуулаг буюу гол барьцалдах чадвар уначихдаг. Тэгээд ирэхээр гурил урсамтгай, нөгөө ёроол нь хагардаг бууз болж хувирна. Тэгэхээр яах вэ, чанаржуулагч хийх хэрэгтэй буюу сайн чанарын хатуу будаа хийх ёстой. Энэ дээр тодорхой хэмжээний импортоор будаа оруулж ирнэ. Хаана илүү сайн ургасан тэр шилэнцэр, цавуулаг өндөртэй будаагаар үнэтэй авч холино гээд будаа болгон 1 үнэтэй биш. Ноолуур болгон 1 үнэтэй биш гэдэгтэй адилхан будаа болгон өөр өөр. Тухайн ургацын чанар төлөвтэй холбоотойгоор. Энэ дээр мэдээж аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч хооронд өрсөлдөөн маргаан гардаг. Энэ дээр будааны чанар дээр гол зохицуулалт дээр нь бол лабораторийн чадавхыг сайжруулах чиглэлийн ажлууд маш сайн хийгдчихсэн. Жишээлбэл 2024 онд бол чанар дээр ямар ч маргаан гараагүй. Яг нүдэн дээрээ машинаас дээж авлаа, богино хугацаанд оношиллоо, автоматаар оношлоод л юу гардаг ийм сайн юунууд оношлууруудыг тэр лабораторийг тоног төхөөрөмжөө бүрэн хангасан тул энэ дээр нэг стандартын бүх үйлдвэрүүд тариалан эрхлэлтийг дэмжих тэр сан нэг стандартын чанар шалгах багажтай болсон. Ямар нэгэн маргаан гараагүй. Өмнө нь тийм байсан байж магадгүй. Тэгэхээр ийм зүйл ахиж давтагдахгүй болсон.

Гурилын үйлдвэрүүд маш өрсөлдөөнтэй. Үнэхээр хуйвалдаад үнэ нэмээд байсан бол нөгөө импорт орж ирэх ёстой шүү дээ. Энэ чинь 5 хувийн гаалийн татвар шүү дээ. Тийм байгаа биз. Тэгэхээр 5 хувийг даваад л 50, 60 хувийн ашиг

олдог хуйвалдаан байх бололцоо байхгүй байхгүй юу. Үгүй ээ, тэрийг хэрвээ тийм өндөр үнэ дотоод үүсээд байвал импорт орж ирээд л тэрийг чинь нам дарна шүү дээ. Тэгэхээр гурилын үйлдвэрүүдийн дундаж жилийн ашигт ажиллагаа 6-9 хувь байгаа. Энийг бид нар бүр нарийн ингээд тооцсон юм. 6-9 хувийн ашигт ажиллагаатай. Тэгээд өрсөлдөөнтэй. Өрсөлдөөн ширүүссээр байгаад л 9 том үйлдвэр л ажиллаж байна. Одоо ч гэсэн өрсөлдөөн ширүүснэ. Эд нар хоорондоо ямар нэгэн байдлаар хуйвалдах, үнэ барих боломж байхгүй.

Импорт талаасаа татварын маш бага босго шүү дээ. Гаалийн татварын босгон дээр хязгаарлагдана. Дотоодын өрсөлдөөн хязгаарлагдана. Олон мянган тариаланчид байна. Дандаа уралдаж өөрсдөө тэр чанартай будаа олж авахын төлөөх өрсөлдөөн явагддаг. Маш их өрсөлдөөнтэй. Тэнд очиж байгаа баялаг маш олон хүнд хуваарилагддаг ийм л харьцангуй их шударга салбар.

Ц.Даваасүрэн: Тийм байх. Тэгэхдээ бид нар бас манайхны хоорондын бие биеийгээ үгүйсгэх гэсэн бие бие рүүгээ чулуу шидсэн зам байж магадгүй. Үгүй ээ, нээрээ 5 хувийн импортын татвараас дээш ашиг хийж чадахгүй шүү дээ. Хэрвээ тэрнээс дээш гараад ирэх юм бол импортын гурил ороод л ирнэ шүү дээ. Тэгэхгүй бас тэр үед юу явсан гэхээр ерөөсөө ингээд л хуйвалдаад л бараг 2 дахин, 3 дахин үнийг нь нэмчхээд байдаг юм гээд тархи угаалт яваад байгаа байхгүй юу. Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Би бол дэмжиж байгаа. Тэгээд гол нь нөгөө зорилго нь зөв ч арга нь буруу байгаад байна гээд байгаа нь импортын татварыг тэглэдэг дээр шүү. Үндэсний үйлдвэрлэлүүдээ унагаачих гээд байна. Унагааж байна. Тэгээд үндэсний үйлдвэрүүд унаад босож ирэх гэж энэ чинь 5-10 жил шүү дээ. Бид нар импортын гаалийн татварыг тэглээд, 1 жил болоод л буцаагаад л яаж байна. Тэгээд гол юм яах вэ үнэ өсчих вий гэсэн болгоомж л байгаад байна шүү дээ. Тэгэхээр дотоодын энэ монополын эсрэг өрсөлдөөний тухай хуульд дээр энийгээ яаж зохицуулах гэж байгаа вэ. Юу гэж харж байгаа вэ гэдэг. Хэрвээ тэгвэл үнэ өсвөл гэсэн утгаар асууж байгаа юм шүү.

2-т асар их хэмжээний хөнгөлөлттэй зээлүүд олгогдоод яваад байна. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд 200 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлүүд гурилын үйлдвэрүүд улаан буудай тариалахад олгосон. Цаашид ч хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээлүүд бусад салбарт олгоод явна. Энийг бас оновчтой байх, үр дүнтэй байх, зорилго доо хүрэх тал дээр яаж анхаарч ажиллаж байгаа вэ гэдэг ийм 2 асуулт байна.

Ц.Даваасүрэн: 2 асуулт байна. 2 асуултын хариулт. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Олгож байгаа зээл нь 200 тэрбум гээд өндөр дүнтэй сонсогдож байгаа байх. Өндөр дүнтэй сонсогдож байгаа 200 тэрбум. Гэхдээ улсын төсвөөс гарч байгаа нь 20 тэрбум. Тэр 20 тэрбумыг бид нар хөшүүрэг болгож, зээлийн хүүгийнх нь тодорхой хувьд нь шингээж өгсөн болохоор энэ нь өөрөө 200 тэрбум болж очиж байгаа. Тэр 200 тэрбумыг арилжааны банк өөрөө судалгаагаа хийгээд эрсдэлээ хүлээгээд олгож байгаа. Тэгэхээр энэ өмнө бол 20 тэрбумыг сайд өөрөө хуваарилаад 20 тэрбумын хэмжээнд төсвийн хэмжээнд шийдэл гардаг байсан бол одоо энэ 20 тэрбум чинь арилжааны банкнуудтай хамтраад хөшүүрэг болгоод ашигласнаар 200 болоод нийлүүлэлт нэмчхэж байгаа. Тэгэхээр энэ бол их зөв байна гэж бид нар үзээд байгаа. Аль болох л хувийн хэвшилдээ бид нар

хөнгөлөлттэй, урт хугацааны хөрөнгө оруулалтын зээлийг л эргэлтийн зээлийг л олж өгөхийн төлөө явж байгаа шүү дээ. Тэгэхээр үр дүн их сайн гарсан. Үнэхээр сая зарим гишүүн шүүмжлэлтэй хандаад байгаа. Үгүй.

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүн асуултаа асууя Д.Батбаяр.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр манай Монголын зах зээл бас их онцлогтой л доо. Юмны үнэ байнга өсөж байдаг. Тэгээд нэгэнт өсчихсөн бол ерөөсөө доошоо буудаггүй. Буулгадаггүй ийм онцлогтой зах зээл байгаа юм. Бензин шатахууны үнэ өссөн хувиасаа хэд дахин илүү үнээр эцсийн бүтээгдэхүүнүүд нь өсөөд иргэддээ хүрчихдэг ийм онцлогтой. Яах вэ, бизнесийнхэнд бол асуудал бас байдаг. Аргагүй л дээ дөнгөж 30 гараад л явж байгаа идэр залуу салбар шүү дээ. Тэгэхдээ бас нэг юм байсан. Тэр юу вэ гэхээр сүүлийн хугацаанд яах вэ Алтан тариа гэдэг компани гурилынхаа үнийг бол буулгаж байсан ийм түүхтэй. Өөрийн юм гэдэг чинь ийм сайхан байдаг байхгүй юу. Үндэсний үйлдвэрлэл. Ёс зүйтэй байна гэдэг энэ. Эх оронч байгаагийн жишээ байхгүй юу. Манай бизнесийнхэнд бас суралцах зүйл их байгаад байгаа юм. Тэгээд сүүлийн хагас жил, жил хагасын хугацаанд хөдөө аж ахуй, тэр дундаа газар тариалангийнхан яг энэ гурилын үйлдвэрүүд бол үнэхээр хүнд байдалд байсан. Аль хэдийнээ нэг жил хагасын хугацаанд 1 биш бүр 2 давлагаанд өртчихөөд байна. Өнгөрсөн жил сонгуулийн жилд гурилын үнийг барих зорилгоор гаалийн татварыг нь багасгачихсан. Үүнээс болоод гурилын үйлдвэрүүд зогсохдоо хүрсэн гэж хэлж болно. Энэ бол жилийн өмнөх асуудал Энхбаяр сайд аа. Одоо юу болсон бэ гэхээр сая энэ өвөл болсон нөгөө эрчим хүчний үнийн чөлөөлөлт чинь ахиад 2 дахь давлагаа болоод 2 дахь цохилт болоод ороод ирчихсэн байхгүй юу. Тэгэхээр бидэнд бол тодорхой хэдэн зүйл байгаа шүү дээ. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үү. Дэмжих ёстой. Яаж дэмжих вэ гэдэг дээр цогц бодлого хэрэгтэй. Энэ гаалийн татварыг бууруулсан энэ шийдвэрийг хүчингүй болгох нь маш зүйтэй асуудал. Энэ дээр нэмээд ахиад нэг асуудал байна. Тэгвэл энэ гурилын үйлдвэрүүдийг цаашид нь ахиад яаж дэмжих вэ. Энэ нийгмийн даатгалын шимтгэл, орлогын албан татвар дээр ямар нэгэн бодлого байгаа юу. Сая эрчим хүчний үнэ өсчихлөө. Энэ бол яах вэ гэхээр үйлдвэрлэлийн өртөг өсөж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр яг энэ хэрэглэсэн хэрэглээ дээр нь эрчим хүчний татаас гэж юм байх уу. Ийм цогц бодлого байх уу. Яагаад гэхээр энэ чинь жилийн дараа ахиад л энэ асуудал ороод ирнэ гэсэн үг байхгүй юу. Тэгээд үнэхээр бид нар үндэсний үйлдвэрлэлээ дэмжье гэж бодож байгаа бол үнэхээр бид нар сэтгэлтэй гурил үйлдвэрлэгч нартай байа гэж бодож байгаа ганцхан асуудлыг гал намжааж байгаа юм шиг шийддэг биш цогцоор нь дэмжээд явдаг, шийдээд явдаг ийм байдалд ормоор байна. Тэгээд юм бол хар юм уу цагаан байна гэж байхгүй. 1 бол нэмдэг, 1 бол дэмждэг, 1 бол дэмжихгүй гэсэн ийм ойлголт байж болохгүй.

Тэгэхээр аль аль тал дээр нь бид нар уян хатан бодлого барих ёстой гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр асуулт байна. ... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут нэмж өгье. Батбаяр гишүүний микрофон.

Д.Батбаяр: Тэгэхээр миний асуулт юу вэ гэхээр энэ гурилын албан татварыг гаалийн албан татварыг сэргээхээсээ гадна ахиад эрчим хүчтэй холбоотой, үйлдвэрлэлийн өртөгтэй холбоотой гурилын үйлдвэрүүдийг дэмжих ямар бодлого байгаа яам барьж байгаа вэ гэдэг асуулт байна.

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайдын микрофоныг өгье. Асуултад хариулъя.

Ж.Энхбаяр: Өнөөдөр дундаж үнэ, үйлдвэрийн үнэ 1500-2000-ын хооронд үндсэндээ маш хямд байгаа. Одоо ууж байгаа кофе, ууж байгаа сүү, өдөр тутмын хэрэглээнд ер нь дундаж өрхийн гурилын хэрэглээ 25 мянган төгрөг гэж гарсан. Маш бага хэрэглэж байгаа. Тэгэхээр энэ нэг тийм айхтар амьжиргаанд нөлөөлөөд, дарамт болоод байгаа бүтээгдэхүүн биш. Хамгийн гол нь стратегийн буюу аюулгүй байдлын гол нөөц болдог л бараа. Тэгэхээр энийгээ бид нар дотроо тарьж ургуулж нөөцөлж болзошгүй эрсдэлийг даван туулах чадавхтай болох ёстой. Татварын саяын тэр цохилтууд бол тантай санал нэг байна. Амаргүй байгаа.

Гэхдээ тариаланчид маань зүтгээд байна. Одоо тариалалт хийх гээд хүлээж байна. Их Хурлынхаа бодлого шийдвэрийг хүлээж байна. Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбоотойгоор салбарын хөгжлийн татварын иж бүрэн өөрчлөлтийг оруулж ир гэдэг үүргийг Сангийн яаманд өгчхөөд, Сангийн яам яг боловсруулалт дээр ажиллаж байна. Энэ хаврын чуулганд багтаж бүсчилсэн хөгжил салбар салбарын онцлогт зориулсан хөгжлийн татварын бодлого явна. Татвар өөрөө хөгжлийн төлөө явах ёстой. Бүтээмжийн төлөө ажлын байр бий болгохын төлөө үйлдвэрийг дэмжихийн төлөө явах ёстой гэдэг ийм үүрэг Засгийн газар дээр Сангийн яаманд хүргэгдээд ажлын хэсэг нь гарчихсан боловсруулалт хийгээд явж байгаа. Энэ хүрээнд бид салбарт хэрэгтэй бүх л татвар бодлогын асуудлуудаа Сангийн яамандаа саналаа хүргүүлчихсэн байгаа. Ингээд энэ хаврын чуулганд цогцоор орж ирэх байх гэж байгаа бодож байна.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Өглөөний мэнд. Би бас сүүлийн 4, 5 жил газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн салбарт гишүүн болохоос өмнө ажиллаж байсан юм. Тэгээд яах вэ, газар тариалангийн салбарыг бага зэрэг гадарладаг болсон юм. Ер нь яах вэ, аль ч улсад нэг ийм харьцангуй давуу талын онол гээд өөрөөр хэлбэл, яг үнэндээ бид гурилын үйлдвэр учраас л тэтгээд, дэмжээд, төрөөс дэмжээд бодлогоор дэмжээд байгаа болохоос биш манай газар тариалангийн салбар бол үнэхээрийн хүнд шүү дээ. Ямар ч өрсөлдөх чадвар байхгүй. Нөгөө талдаа тэр улаан буудайн урамшуулал гээд олгоод байгаа чинь тэнд гарч байгаа тариалалтын зардал, үр бордоо, техник хэрэгсэл, бүгдэд нь гарч байгаа зардлыг л бодоод өгчихдөг юм билээ. Яах вэ, ний нуугүй хэлэхэд бол сая Батбаяр гишүүн ч бас хэлчихлээ. Өнгөрсөн жил бид нар сонгуулийн өмнө болоод л баахан гурилын татвар, импортын татвар тэглээд л нэг талаасаа ингээд төр дэмжээд байгаа юм шиг мөртөө энэ газар тариалангийн салбарыг дэмжээд байгаа юм шиг мөртөө нөгөө талаасаа ийм сонгуулийн үеийн өмнөх амлалтаасаа болоод нөгөө гараараа ахиад буцааж унагах гэж байгаа байхгүй юу. Жилийн дараа энэ хугацаанд ямар их хүндрэл газар тариалангийн салбарт гарсан бэ гэдгийг миний асуулт ингээд яамнаас асуух юм. Тэгэхлээр бид нар өнгөрсөн хугацаанд 212 тэрбум төгрөгийг зөвхөн гурилын салбарт дэмжлэг болгож үзүүлсэн мөртөө өнгөрсөн 1 жилийн хугацаанд яг газар тариалангийн салбарт эдийн засгийн утгаараа ямар хохирол учруулчхав. Энэ гурилын гаалийн татвар квотгүй болгосноор татвар тэглэснээрээ 1 дэх асуулт нь. Яг ийм нарийвчилсан судалгаа та нар ер нь хийсэн үү. Газар тариалангийн салбарт яг эдийн засгийн утгаараа ямар хохирол учруулчхав.

2 дахь нь гурилын үйлдвэрүүдийн салбарын өрсөлдөх чадварыг сая Батбаяр гишүүнтэй санал нэг байна. Яг үнэндээ зөвхөн дэмжлэг үзүүлэхээс, урамшуулал

өгөхөөс гадна бид нар тэр цогцоор нь сая Энхбаяр сайдын хариултад гарч л байна л даа. Тэр татвараар, өөр юугаар дэмжих юм. Бид нар өрсөлдөх чадварыг нь сайжруулахгүй бол зөвхөн урамшуулал гээд яваад байх юм. Яамны бодлого юу вэ энэ дээр.

3 дахь асуудал нь энэ мэдээллийн зөрүү яваад байна шүү. Сайдын мэдээлэлд болохоор өнгөрсөн хугацаанд энэ жилийн 5 ноднингийн 5 сарын 1-ээс хойш гэдэг чинь 1 жил болж байна шүү дээ. Жилийн хугацаанд гурилын үйлдвэрлэлийн дотоодын гурилын үйлдвэрлэлийн салбар 1 нь болохоор 40 гаруй хувиар буурсан гэж ярьж байна. Яг бид нарт өгсөн мэдээлэл болохлоор 36 хувиар гээд байна. 4 процент ч гэсэн их шүү. Яг хэдэн хувиар буурсан юм. Энэ мэдээллээ нэгтгээд өгөөрэй. Хамгийн гол зүйл нь болохоор сая Энхбаяр сайдын бидэнд өгсөн мэдээлэл дотор гурилын үйлдвэрүүдийн ашиг бол их тийм өндөр биш. Сүлжээ дэлгүүрүүд 30-40 хувь нэмээд байна гэж байна. Өөрөөр хэлбэл гурилын үнийн нэмэгдэл гэдэг чинь сүлжээ дэлгүүрүүдээр яваад байна. Яг худалдааны салбарууд дээр. Яг үүнтэй адилхан салбарууд дээр нийтлэг харагддаг. Манайхан ... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: 1 минут нэмж өгье. Г.Ганбаатар гишүүнд.

Г.Ганбаатар: Үгүй ээ яах вэ, тэгэхдээ 30-40 хувь гэдэг чинь үгүй ээ, үгүй. Ганбаатар гишүүн ээ, ойлгож байна. Би таныг гэж хэлээгүй байна. Худалдааны салбарууд, сүлжээ дэлгүүрүүд 30-40 хувь гэдэг чинь ер нь би зөвхөн гурил дээр биш АПУ-ийн архи гээд тэгэхэд гурил ярьж байгаад архи ярьсанд уучлаарай. 50 мянган төгрөгийн архи нь бааранд шууд үйлдвэрлэгчээсээ 4 дахин өндөр үнэтэй байж байгаа байхгүй юу. Ер нь тэгэхдээ 1 иймэрхүү, хэдийгээр чөлөөт худалдааных ч гэсэн бид энэ үйлдвэрлэгчээсээ өндөр ашиг олдог талаас ямар бодлого хэлцэл хийгдэж байгаа юм бэ гэдэг асуулт байна. Өөрөөр хэлбэл энэ чинь үйлдвэрлэгчээсээ 3, 4 дахин, гурил дээр бол 30-40 хувь юм байна. Энэ асуулт дээр.

Ц.Даваасүрэн: Тэр тоон мэдээлэл дотор 1 ийм юм яваад байгаа юм. Тэр нь гишүүдийг төөрөлдүүлээд байгаа байхгүй юу. Тэр бодитой юу, үгүй юу гэж. Импортын гурилын хэмжээ хуучин 4 хувь байсан гэж зах зээл дээр. Одоо 30 гаруй хувь болчихсон гээд байгаа юм. Тэгэхээр тийм хэмжээний хохирол гурил үйлдвэрлэгч дээр л оногдсон гэсэн үг шүү дээ. Энэ дээр л нэг тодорхой хариулт авах гээд байна шүү дээ.

Ж.Энхбаяр: Би Үндсэний статистикийн хорооны статистикийн эмхэтгэлээс дандаа тоо авч байгаа. Гурилын хэрэгцээний 59,1 хувийг дотоодын үйлдвэрээс, 40,9 хувийг импортоор хангаж байгаа ийм тоо. Үнэхээр импорт эрс нэмэгдсэн л дээ. Гэхдээ ийм зүйл гишүүд ээ, салбар бол тариаланчдыг аль болох энэ улаан буудай тарих тал руу нь чиглүүлээд, энэ тарилтын бодлогыг хийнэ. Хурааж авснаараа дотооддоо гурилаа үйлдвэрлэх миний ярьж байгаа үнэ бол дандаа үйлдвэрийн үнэ. Бид нарын хамгийн сул тал өргөн дэлгэр газар нутаг тээврийн зардал их. Тэр алслагдсан бүс нутагт очихын тулд гурил өөрөө их хямд байгаа байхгүй юу. Хямд бүтээгдэхүүнийг үнэтэй тээврээр 1000, 2000км тээвэрлээд очихоор нөгөө үндсэн бүтээгдэхүүнээсээ илүү давсан өртөг шингээгээд байгаа асуудал байгаа. Энийгээ бас бид нар ойлгоод явахгүй бол нэг зүйлээр нөгөөг үгүйсгэж болохгүй.

Тэгэхээр энэ чинь үнэ бол яг л тэр зах зээл, зай өртөг энд таарсан л ийм өсөлтүүд яваад байгаа. 1 зүйл манайд гадаад болон дотоод худалдааны хуулийн зохицуулалт байхгүй. Яаралтай гадаад худалдааны хуультай болмоор байгаа юм. Тэгээд энийг хариуцдаг, эрхэлдэг, бас нэг тодорхой хэмжээнд зохион байгуулж, үнийн бодлого дээр анхаарч байдаг ийм төрийн институц зайлшгүй бол шаардлагатай. Хэн нэг энд хариуцах ёстой байгаа. Тэгээд энэ бол жоохон зохицуулалтгүй байгаатай холбоотой байх. Энэ бол яг л зах зээлийн зарчмаараа л тэр яваад байгаа. Гол нь бид бол тарих үйлдвэрлэх. Тэгээд үйлдвэрийн үнэ их бага байгаа шүү. 1кг гурил 1500-2000 төгрөг. 9 үйлдвэрийн үнэ. Энэ бол маш бага үнэтэй гэсэн үг. Эцсийн бүтээгдэхүүн шүү дээ.

Ц.Даваасүрэн: 4 асуулт байсан даа.

Ж.Энхбаяр: Яах вэ, хохирол ерөөсөө би 40 хувиар л бид нар дотоод зах зээлээ үндсэндээ гадна талдаа алдаж байна л гэсэн үг. Тэр хэмжээний дотооддоо хийх ёстой байсан нэмүү өртөг, үйлдвэрлэл, зах зээлээ бид нар хойд хөршдөө алдаж байна гэсэн үг. Тэгээд үүний цаана дотоод хэчнээн татвар төлөх бололцоо байсан, хэчнээн ажлын байр, цалин байх ёстой байсан тэр болгоноо л бид нар гадна талдаа л алдаад байна гэсэн үг. Импортын тоо багцаа би буруу санаж магадгүй 60 гаруй сая долларын импорт гурил дээр хийгдчихсэн байгаа. Манай бодлогын дарга ахиад нарийн тононд хэлээдэх тэгэх үү. Тоонууд. Тариалалт яаж унав. Ургац яаж унав. Импортод хэчнээн валют алдав.

Ц.Даваасүрэн: Нарийвчилсан хохирлыг Болорчулуун дарга. Ер нь ямар хэмжээний хохирол учирсан юм бэ. Импорт 60 сая гэдэг чинь бол бас л валютын нөөцийг сорсон л гэсэн үг шүү.

Ц.Болорчулуун: Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Ганбаатар гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр гурилын хангамж дотоодын үйлдвэрлэлийн түвшин 2019-2023 онд бол яг тогтвортой буюу дотоодын хэрэгцээгээ 98-100 хувь хангаж байсан. Ингээд он оноороо гараад жилдээ 3-4 мянган тонн гурил л импортоор оруулж ирдэг, бусдыг нь бол дотоодын үйлдвэрлэлээр хангадаг байсан. Яах вэ, энэ шийдвэр гарсантай холбоотойгоор 2024 оны тариалалт 20 хувиар буураад, 56 мянган тонноор ургац буураад явчхаж байгаа учраас 40/60 гэсэн энэ харьцаа бол гараад ирж байгаа юм. Тэгэхээр энэ зөвхөн гурилын үйлдвэрүүдийн асуудал бас биш, энэ гурил үйлдвэрлэлд ордог ... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Дутуу байна уу. Дутуу байна гээд байна. 5 номерыг дахиад 1 минут.

Ц.Болорчулуун: Тэр гурил үйлдвэрлэлд харилцаанд ордог бүх субъектүүд буюу тухайлах юм бол техникийн дилер компаниуд өнгөрсөн жил 45 тэрбум төгрөгийг зээл, банкны зээл аваад, тэр дээр бас төлөх эрсдэл нь үүсчхэж байгаа юм. Дээрээс нь тариаланчид маань өнгөрсөн жилийн хугацаанд бас 182 тэрбумын төгрөгийн зээл авсан. Энэ дээр эргэн төлөлт дээр бас асуудал гараад, гурилын үйлдвэрүүд бол яг дотоодын одоо бол тоног төхөөрөмжийн шинэчлэл дээр бол ямар нэгэн асуудал байхгүй. Зөвхөн эргэлтийн хөрөнгийн зээл л жилд 100 орчим тэрбум төгрөгийн зээл олгож байгаа. Энэ эргэлтийн хөрөнгийн зээл гэдэг жилдээ гарч байгаа 400 мянган тонн буудайны 100 мянган тонн буудайг авах хэмжээний зээлийг зээлийн эх үүсвэр дээр хүүгийн татаас олгох замаар арилжааны банкны эх

үүсвэрийг ашиглаж л гурилын үйлдвэрүүд дэмжлэг үзүүлж байгаа. Тэрнээс яг гурилын үйлдвэрүүд дээр бол хөрөнгө оруулалтын зээлүүд олгоод байгаа асуудал бол байхгүй байгаа.

Ц.Даваасүрэн: Г.Ганбаатар гишүүн тодруулна.

Г.Ганбаатар: Миний асуулт уг нь агуулгыг нь ойлгосонгүй юу. Ерөнхийдөө энэ квотгүй болоод татваргүй болсноороо өнгөрсөн жил үнэхээрийн гурилын үйлдвэрүүд чинь унаад, дээрээ өрийн сүлжээ үүсээд, үндсэндээ гурилын үйлдвэр чинь борлуулалт бага болоод, дээрээс нь нөгөө тариаланчдадаа мөнгийг нь өгч чадахаа байгаад, тэгээд тэр үр тариа тэр олон мянган зээл та нар нэг ийм нарийвчилсан судалгаа тоо. Та бол яах вэ, сая 45 тэрбум, 182 тэрбум, 100 тэрбум гээд ерөнхий юм ярьчих юм. Яг ийм юмыг та нар бодлогын яам хийж байх ёстой шүү дээ. Яг нэг жилийн ийм хортой шийдвэрээс болоод газар тариалангийн салбарт ийм хэмжээний эдийн засгийн хохирол учирч, ахиж ийм сонгуулийн өмнө иймэрхүү шийдвэр гаргаж болохгүй байхгүй юу. Зөвхөн яг үнэндээ бол үүнээс иргэдэд хямд гурил өгөхөөсөө илүү газар тариалангийнхаа салбарыг та нар унагачихсан шийдвэр гаргасан шүү дээ. Та нар юу байх вэ, өнгөрсөн Улсын Их Хурал 5 сарын 1-нд. Тэгээд иймэрхүү юмнуудыг та нар их тодорхой ярьж байх ёстой шүү.

Ц.Даваасүрэн: Санал хэлчхэв үү. Санал хэлчихлээ. Дутуу хариулсан гэдэг дээр.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад гишүүд тодорхой асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Нэрээ өгье. Батжаргал гишүүн байна. Батжаргал гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн үгээ хэлье.

Ж.Батжаргал: Тэгэхээр асуудалд их бодитой хандмаар байна. Ярьж байгаа асуудлыг сонгуультай ч холбодог аль нэг салбарын эрх ашгийг дэмжиж байгаа байдлаар ч хийгээд байгаа юм шиг ийм байдлаар илэрхийлж боломгүй байна. Яагаад төр хөдөө аж ахуйн салбараа дэмжээд байгаа юм гэхээр энэ хөдөө аж ахуйн салбар өөрөө хүн амын амь амьжиргааных нь гол салбар. Хүнс хэрэглэдэггүй хүн байна уу. Хувцас өмсдөггүй хүн байна уу. Тийм учраас бид энэ өргөн түмнийг хүнстэй, хувцас хунартай байлгахын тулд энэ салбарыг дэмжиж байгаа юм. Нэг. Дэмжихийн бас шалтгаан байгаад байгаа. Монголын өөрийнх нь уур амьсгал их өөр, хөрснийх нь бүтэц агууламж их өөр. Тийм учраас дэлхийн хөдөө аж ахуй хөгжчихсэн улс орнуудтай харьцуулах юм бол манай бүтээгдэхүүний нэгжээс авдаг хэмжээ нэлээн бага. Тийм учраас энийг бид төрийн бодлогоор дэмждэг. Өрсөлдөх боломж үнэхээрийн хязгаарлагдмал ийм зүйл гэж.

2 дахь зүйл. Бид 330-340 мянган тонн хамгийн багадаа будаа байвал 230 мянган тонн гурил гаргаад авдаг ийм л улс байхгүй юу. Гэтэл өнгөрсөн жил 64 мянган тонн гурил импортоор оруулаад ирчихсэн, нийт хэрэглээний бараг 20 гаруй хувь. Дээд гурилынхаа бол 82 хувийг, 1 дүгээр гурилынхаа 16 хувийг оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь цаана нь үйлдвэрлэл, газар тариалангийн салбарт чинь дарамт болохоос яах юм бэ. Энэ бол боломгүй зүйл байгаад байгаа юм. Энийг бид засах ёстой. Засахад учир байна. Бодох ёстой юм бий. Баруун бүс нутаг үнэхээрийн л алслагдсан тээвэр логистикийн зардал өндөртэй байгаа юм бол энэ бүс нутагтаа хүнсний хангамж, дан дамаа гурилын хангамж, үнийн тогтвортой байдлыг яаж хангах вэ гэдэг асуудлыг төр тусгайлан бодож

зохицуулалт хийх ёстой. Үүнийг бол би мөнхийн бас бодож яваа зүйл. Үүнийг бид анзаарах ёстой гэж.

2 дахь хэлмээр байгаа зүйл бол монопол элдэв бусын юмнууд байгаа юу гэвэл бас байхыг үгүйсгэхгүй. Энэ нь тарифын бодлогоор биш үндэсний дотоод өрсөлдөөн монополын гэдэг юм уу, энэ зохицуулалтуудаараа явах ёстой зүйл. Энийгээ бид зөв шийдэх ёстой гэж.

Дараагийн нэг зүйл бол яах аргагүй энэ анхдагч үйлдвэрлэлийг боловсруулах салбартай нь хослуулж хөгжүүлж байж л сая үйлдвэрлэлийн хэмжээ ч нэмэгдэнэ. Эдийн засаг ч өснө. Ажлын байр ч бий болно. Хангамж ч нэмэгдэнэ, экспорт ч бий болно. Үнэ цэн орохын тухай ойлголт ерөөсөө энд л байгаа шүү дээ. Тийм учраас газар тариаланг хөгжүүлбэл гээд 60 хэдэн жил зүтгэчихлээ. Энэ жил шинэ аян өрнүүлчихлээ. Тэгвэл газар тариалан хөгждөг юм бол гарч ирсэн бүтээгдэхүүнийг нь үйлдвэрлэдэг боловсруулах үйлдвэрүүдээ бид дагуулж хөгжүүлэхгүйгээр энэ асуудлыг шийдэж чадахгүй шүү дээ. Тэгээд цаана нь хүнсний хангамж ярьж чадахгүй шүү дээ. Тэгээд нөгөө хүнс үйлдвэрлэгч экспортлогч орон болох том зорилтоо хангаж чадахгүй шүү дээ. Тэгэхээр энийг цогцоор нь харж асуудлаа шийдэх ёстой. Тийм учраас энэ гэхдээ дан гурил яриагүй юм шүү. Малын тэжээл ярьсан юм. Өнгөрсөн жил үнэхээрийн зудтай байсан. Дотоодод үйлдвэрлэж байгаа тэжээлээс давсан хэрэгцээ үүссэн. Үүнийг хангахын тулд тэжээлийн импортын татварыг тэглэж байж, тэжээлийн хангалтыг нэмэгдүүлэх ийм бодлого барьсан. Тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн. Гурил талдаа ч үр дүнгээ өглөө. Одоо цаашид бид энэ алдаа ... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн үг хэллээ. Ер нь бол гишүүдийн хэлээд байгаа үндэсний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, стратегийн бүтээгдэхүүн гэдгийг бол бид бас ойлгох ёстой. Энэ бол чухал бүтээгдэхүүн. Саяхан л бид нар ясны гурил идлээ гээд үхлээ, хатлаа гээд л бөөн л юм болж байсан. Ер нь ингээд хорт хавдрын өвчлөл Монгол Улсад өндөр байгаагийн нэг шалтгаан хүнс байж магадгүй шүү дээ.

Тийм учраас ялангуяа хүнсээ дотооддоо үйлдвэрлэх органик үйлдвэрлэл, химийн бордоогүй гурил гаргана энэ тэр гэдэг бол энэ чухал зүйл шүү дээ. Тэгээд ер нь бол иргэдээ зөв авч явна гэдэг чинь төрийн асуудал. Төр чинь өөрөө Их Хурал. Их Хурлыг гишүүн бүрдүүлж байгаа. Тийм учраас гишүүд бас энэ дээр нэлээн нийгэмд зөв ойлголт өгөх, иргэдээ зөв ойлгуулах чиглэлээр явах ёстой. Жишээлбэл, сая импортын татварыг авч хаяснаар юу болсон байна вэ гэж. Наад зах нь 60 сая доллар алдсан байна шүү дээ. Үгүй ээ, энэ чинь валютын нөөц шүү дээ. Валютын нөөц ингээд ховх сорогдоод ирэхээр яах юм. Валютын ханшийн үнэ өснө. Бүх юмны үнэ өснө. Бид нар импортын хэрэглээ өндөртэй гэх мэтээр бид нар нийгэмдээ өөрсдөө бас ингэж зөв тайлбар өгөх ёстой. Тэр гурил үйлдвэрлэгч, тариалан үйлдвэрлэгч хоорондын хэрүүлд автаж болохгүй. Тэд нарын хооронд зөндөө л юм болж байгаа. Нэг нь хямд авлаа, дамлалаа гээд л. Яг яс юман дээрээ Энхбаяр сайдын хэлээд байгаа тэр гурилын үйлдвэрийн ашиг их айхтар бүр хэд нугалчихсан юм байхгүй байх. Тэр импортын татварын 5 хувь дотор л эргэлддэг байх гэж би ингэж бодож байна.

Тэгээд нийгэмд зөв тайлбар өгөөд энэ салбараа зөв авч явах асуудал бол бас төрийн хамгийн чухал асуудал байх гэж бодож байгаа. Жишээлбэл сая Украин, Оросын дайнаар юу болсон. Африкт гурилын хомсдолд орсон шүү дээ.

Бүр хомсдолд орсон. Арабын ертөнц бас тийм. Гэтэл бид нар хомсдолд ороогүй шүү дээ. Энэ юуны ач тус юм. Нөгөө газар тариалан эрхэлж байгаа хүмүүс нөгөө гурил үйлдвэрлэгч нарын л ач тус шүү дээ. Энийг бид нар хэлэх ёстой байхгүй юу. Эд нарын хэрүүл дунд хутгалдах биш, төрийн хүний байр сууриар бид нар хандаж хэлэх хэрэгтэй шүү дээ. Зөв тайлбар өгөхийн тулд бид яагаад амьд үлдсэн юм. Яагаад гурилын үнэ тэр бусад орных шиг хомсдолд орчхоогүй юм. Үгүй ээ, гурилаа бид нар тарьдагтаа л байгаа шүү дээ. Одоо бид нар ОХУ-аас бензин шатахууны хамааралтай. Үгүй ээ, тэгээд дахиад гурилын хамааралтай болж яах гээд байгаа юм. Энэ бүгдийг л бид нар нийгэмдээ их зөв ойлгуулж явах л асуудал.

Ер нь хүнс татаастай байдаг юм. Гурил ч гэсэн, будаа тариалах ч гэсэн, мах. Жишээлбэл мах дэлхийн зах зээл дээр органик мах бол бөөний үнэ нь 8-10 доллар байгаа. Манайд 2 доллар байгаа шүү дээ. Тэгээд хэрвээ манай үнэ дэлхийн зах зээлийн үнэ рүү ороод ирвэл яах вэ, Улаанбаатарынхан, төв суурин газрынхан хашхирч эхэлнэ шүү дээ. Тийм үнэтэй мах авлаа гээд. Тэгэхээр гадаадад яаж зохицуулдаг вэ энэ зөрүүг нь төр татаас өгдөг. Бүх улс орон хүнсний үйлдвэр дээрээ татаастай. Гурил дээр дэлхийн зах зээлийн 50 хувийг ч хангаж байгаа Орос, Украин 2-той бид нар өрсөлдөнө гэвэл үлгэр шүү дээ. Тэд нартай харьцуулж яриад байвал онигоо байхгүй юу. Гурилын зах зээл дээр жижигхэн Монгол чөлөөтэй өрсөлдөнө гээд ингээд солиорох юм бол байхгүй л болно шүү дээ. Энэ гурилын үйлдвэрүүд чинь. Ахиад л ясны гурилаа иднэ. Үнэтэй гурилаа идэж эхэлнэ. Нэг хэсэг хямд идэх байх. Дараа нь үнэтэй идэж эхэлнэ шүү дээ. Тэгэхээр бид нар энэ үндэсний үйлдвэрлэл гэдэг юмны ач холбогдлыг маш зөв ойлгуулахгүй бол болохгүй. Гэхдээ ингээд үндэсний үйлдвэрлэлээ хамгааллаа гээд нөгөө хэдэн үйлдвэрлэгч нар нь үнээ тэнгэрт хадуулдаг бас байж болохгүй.

Сая Ганзориг гишүүн, Батлут гишүүн, Батжаргал гишүүн хэлээд байна шүү дээ. Энийг нь төр зохицуулж өгөх ёстой. Тэр чөлөөт өрсөлдөөнийг зохицуулах тэр монополын эсрэг хуулиараа зохицуулах энэ хуулиуд байна. Энэ бүтэц нь ажиллахгүй байна шүү дээ манайд. Ерөөсөө ажиллаж чадахгүй байна. Тэгээд бид нар энэ үнийн зөв тогтолцоог бий болгохын тулд эдгээр байгууллагуудаа яг жинхэнэ утгаар нь ажиллуулдаг болгох хэрэгтэй. Тэгээд төр ч гэлээ гэсэн ер нь асуудалд их зөв ханддаг байхгүй бол бид нар яг ийм маягаараа бодлогогүй яваад байх юм бол валютын нөөцийн хомсдол байнга ордог байна. Жишээлбэл хүнс дээр бид нар валютын 1 тэрбум орчим долларын хувцас хунар, хоол хүнс гаднаас авч байгаа. Гэтэл баян ядуугүй, бүгдээрээ машинтай. Машин нь хүнс нь машины хүнс нь 2 тэрбум доллар. Хүнийхээ хүнснээс 2 дахин давчихсан. Валютын нөөцийг хамгийн их сорж байгаа юм нь машины хүнс. Хүнээсээ лүү 2 дахин болчихсон. Яагаад ийм байдалд орсон юм. Бидний буруу шүү дээ. Төр авч явж чадахгүй байгаа бидний л буруу байхгүй юу. Тэр зохицуулалтыг нь хийж өгөхгүй байна, тэр татвар тарифыг нь зохицуулахгүй байна, машины импортыг зохицуулахгүй байна, тэгээд л валютыг нь ховх сордог юм нь юу вэ машины хэрэглээ.

Тийм учраас бид нар бас энэ татварын зохицуулалт гэдэг юман дээр маш зөв хандах, тэгээд энэ монополын эсрэг чөлөөт зах зээлийг зохицуулах энэ эрх зүйн орчнуудынхаа тэр бүтцийг байгууллагуудыг зөв ажиллуулдаг болгоё гээд байгаа э гишүүдийн саналуудыг бид нар анхаарах ёстой. Тэгээд энэ гурилын асуудал бол стратегийн хүнсний асуудал, хүн амын хүнсний аюулгүй байдлын асуудал гэдгийг бид бас ойлгох ёстой.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 16 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 75 хувиар дэмжигдсэн байна. Ж.Ганбаатар гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баясгалан чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

11.53 цаг.

3 дахь асуудалдаа оръё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Өмнөх хуралдаанаар бид нар хэлэлцсэн асуудал байгаа. Бид нар өмнөх хуралдааны Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны тайланг хэлэлцээд, энэ зөвлөлийн бүтцийг боловсронгуй болгоё. Хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгоё. Энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулъя гэж тогтсон байгаа.

Тэгээд “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг та бүхэнд тараачихсан байгаа. Тэгээд энэ байгаа гишүүд бол өмнө нь ялангуяа Солонгос, Япон энэ тэрийн энэ тогтолцоог судалсан гишүүд байгаа. Дээр нь нэмж орох гишүүд байвал нэрээ өгчихье. Батбаяр гишүүн, Баясгалан гишүүн оръё гэж байна. Эдгээр гишүүнийг нэмээд оруулчихъя. Энэ тогтоолын төслийг би та бүхэнд танилцуулаадахъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангуулах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус, бие даасан, байнгын ажиллагааг хангахад чиглэсэн эрх зүйн орчин болон бүтцийг боловсронгуй болгох юм шүү. Энэ буруу биччихсэн байна. Эрх зүйн орчин болон бүтцийг боловсронгуй болгох асуудлыг судлан санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийг би өөрөө ахлах юм. Ажлын хэсгийн гишүүнээр Батболд гишүүн, Батбаяр гишүүн, Батжаргал гишүүн, Батлут гишүүн, Ганзориг гишүүн, Мөнхсоёл гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Баясгалан гишүүн нар орохоор санал ирүүлсэн байна.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулах гэсэн ийм 2 заалттай.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу. Алга байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцож, 10 гишүүнтэй 62,5 хувиар дэмжигдсэн байна.

Батбаяр гишүүн дэмжсэнээр протоколд авлаа. Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж ... Цогтбаатар дэмжсэнээр бас протоколд авлаа. Ингээд Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж дууслаа.

11.55 цаг.

4 дэх асуудал.

“Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийг сонгох тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д Монгол Улсын Ерөнхий аудиторовыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаатайгаар томилохоор заасны дагуу Монгол Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд Сандагийн Мягмарсүрэнг санал болгосон байх тул Төсвийн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголыг явуулж, тайлан гаргах санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна. Иймд “Монгол Улсын ерөнхий аудиторовын албан тушаал нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан байгаа.

“Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Даръя. Кнопоо даръя. Г.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Г.Ганбаатар: Би үг л хэлье. Асуулт ч юу байх вэ. Хэн гэдэг хүн гэнэ ээ. Тэр Их Хурлын даргаас нэр дэвшүүлж байгаа тэр талын мэдээлэл байна уу. Мягмарсүрэн гэсэн үү, хэн гэсэн.

Ц.Даваасүрэн: Магнайсүрэн, Сандагийн Магнайсүрэн.

Г.Ганбаатар: Сандагийн Магнайсүрэн мэдэхгүй. Зүгээр ер нь ер нь яах вэ. Уг нь энэ хамтарсан засаг гээд, дээрээс нь яг энэ төр засаг энэ авлигатай, энэ төсвийн хулгайтай янз бүрийн юмтайгаа тэмцье гэж байгаа бол уг нь энэ санал болгож байгаа хүмүүсээ цөөнхөөсөө, эсвэл хамтарч байгаа Ардчилсан нам чинь цөөнх гэх нь ч хаашаа юм. Хамтарсан засагт нь арай цөөнх юм уу. Дандаа ингэж явахгүй байлгүй. Уг нь тэгж өгвөл их зүгээр юм байгаа юм шүү дээ. Аудитынхаа даргыг, АТГ-ынхаа даргыг эд нар бол уг нь сөрөг хүчин гэдэг юм уу, цөөнхдөө өгөх юм бол жинхэнэ утгаараа авлигатай тэмцэх, энэ төсвийн хулгайтай тэмцэх хүсэл эрмэлзэл байна гэж харагдах юм байгаа юм. Тэгээд яах вэ Магнайсүрэн гээд хүний нэр ороод ирж байгаа юм байна. Миний саналыг бас цааш нь протоколд тэмдэглээд үлдээчихнэ биз.

Үнэхээрийн тийм хүсэл зориг байгаа бол уг нь ингэж явбал энэ улс орон бас нэг хяналттай болох юм байгаа юм. Үндсэндээ бид нар бол хяналт гэдэг юм байхгүй болчихлоо шүү дээ. Тэгээд хамтарсан нэрийн доор бүр заваарлаа. Уг нь энэ чинь хамтарсан гээд хяналтынхаа менежерүүдийг тэр ТӨК-удынхаа менежерүүдийг өгөөд байгаа юм бол тэр АТГ, тэр аудитынхаа дарга нарыг яагаад юу яаж болохгүй гэж Ардчилсан намаас санал болгож болохгүй гэж. Үүнийг би бас протоколд тэмдэглэж үлдээхийг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Зөв зөв. Ганбаатар гишүүний хэлж байгаа саналыг бас анхаарах ёстой. Яагаад гэвэл бас энэ асуудал даргын зөвлөл дээр танилцуулагдах ёстой. Даргын зөвлөлд бол улс төрийн намын намын бүлэг, намын дарга нар энэ тэр бүгд орсон байгаа учраас энэ дээр бас яригдах байх гэж ингэж бодож байна.

Тогтоолын төслийг би та бүхэнд танилцуулаадахъя.

“Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийн сонгох тухай”

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1.1 дэх заалтыг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь.

Монгол Улсын Ерөнхий аудитын албан тушаалд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулахаар товлосугай.

Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Дамдиннямыг сонгосугай.

Нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг 2025 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл хугацаанд хүлээн авахаар тогтоосугай.

Нэр дэвшигчийн сонсголын талаарх нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулахыг Төсвийн байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоол байгаа юм.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо уг тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Яагаад тэгчхэв. Тэгвэл горимын санал гаргачихъя. Горимын санал гаргачихъя. Зарим гишүүдийнх нь эсрэг ажилласан юм байна. 3 гишүүн эсрэг байна. Мөнхтулга гишүүн, Цогтбаатар гишүүн, Баясгалан гишүүн. Баясгалан гишүүн санал гаргачих.

Ж.Баясгалан: Төхөөрөмж ажиллаагүй, тэгээд хонх нь бас хоцорч дуугарсанд бол дахиад саяын саналыг хүчингүй болгоод, дахиад санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

Ц.Даваасүрэн: Баясгалан гишүүний гаргасан горимын саналаар саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Батжаргал гишүүнийх бас эсрэг яваад, Цогтбаатар чинь дахиад эсрэг явчхаад байгаа юм уу. Алив микрофонд дахиад Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Сүүлийн 2 санал хураалт дээр төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахиж явуулж өгөөч гэж горимын санал гаргаж байна.

Ц.Даваасүрэн: Тэгвэл энэ чинь ахиад 2 санал хураалт явах нь. Саяын хүчингүй болгохыг дэмжих санал хураалтыг хүчингүй болгосон байна. Энийг дахиад хүчингүй болгож өгөөч гэсэн санал хураалтыг явуулъя. Гишүүд анхаараарай. Анхааралтай хандахгүй бол харин суудлаа солих юм уу. Цогтбаатар гишүүн суудлаа сольчихъё энэ хооронд. Гарч болохгүй байх. 2 дахиа давтаад байна шүү дээ. Суудлаа сольчих.

Цогтбаатар гишүүний саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Техниктэй холбогдолтой ингээд байгаа учраас ил санал хураалт явуулчихъя. Тэгээд больё. Ингээд техникийн шалтгаан гараад байгаа учраас Цогтбаатар гишүүнийх чинь 3 удаа эсрэг санал гарчихлаа.

Тийм учраас Дэгийн тухай хуулийн 10.4-ийн ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарах зэргээс санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулахаар зохицуулж байгаа юм байна.

Тэгвэл Дэгийн тухай хуулийн 10.4-ийн дагуу энэ санал хураалтыг илээр явуулъя гэсэн санал хураалтыг явуулъя. Илээр явуулъя гэдэг санал хураалт. Гараар. 16-10 байгаа учраас илээр явуулах санал хураалт дэмжигдлээ.

Ингээд “Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсголоор сонгох тухай” тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томьёоллыг ил санал хураалтаар явуулъя. 9 юм биш үү. Дэмжихгүй байгаа юм байна. 9 юм байна. Санал хураалтад 16 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, хэдэн хувь байна. 56,2 хувиар тогтоолын төслийг дэмжсэн байна. Тогтоолын төсөл дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ